

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2021.02.05

Сүхбаатар сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид энэ сард 1 удаа цахимаар хуралдаж 4 асуудал хэлэлцэн 4 тогтоол баталлаа. Үүнд:

1.Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцээд Сэлэнгэ аймаг байгуулагдсаны түүхт 90 жилийн ойг 2021 оны 07 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэхээр тогтоолоо.

2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын зөвшөөрөл олгох санал өгөх тухай асуудлыг хэлэлцээд аймгийн Засаг даргад санал хүргүүлэхээр тогтов.

3.Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай хэлэлцээд сум, байгууллагууд тухайн жилийн төсвийн төслөө боловсруулан батлахдаа Төсвийн тухай хууль тогтоомжид судалгаа тооцоо, зураг төсөвтэй хөрөнгө оруулалтын ажлуудад төсвийн тооцоолол хийх чиглэлийг үүрэг болгов.

4.Шагналд уламжлах тухай асуудлыг хэлэлцээд Цагааннуур сумын харьяат Довдонгийн Амаржаргалыг Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

Мөн сард Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий Иргэний зөвлөлийн гишүүдтэй аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Нарантуяа уулзалт хийж, санал солилцлоо.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төр, төсвийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээнд чанарыг эрхэмлэж, аливаа ажил арга хэмжээг чанартайгаар гүйцэтгэх, боловсролын сургалтын чанар, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хөрөнгө оруулалтын ажлын чанар, баримт бичгийн боловсруулалтын чанар, иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар гэх зэрэг бүх салбар, бүх шатанд чанарын шаардлагыг хангаж ажиллахыг зорьж аймгийн Засаг даргын 2021 оны А/01 дүгээр захирамжаар 2021 оныг “Чанарыг эрхэмлэх жил” болгон зарлалаа.

Аймгийн Засаг дарга бөгөөд аймгийн Онцгой комиссын дарга Ш.Оргил Ерөө, Хушаат, Жавхлант, Мандал, Цагааннуур, Зүүнбүрэн сумдад ажиллаж, сум орон нутгийн өвөлжилт, сумдын Онцгой комисс-шуурхай штабын ажлын бэлэн байдалтай танилцаж, Улсын Онцгой комиссын шийдвэрийн дагуу “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжээд байгаатай холбогдуулан сумдын Онцгой комиссыг урьдчилан сэргийлэх болон ухуулга, сурталчилгааны ажлыг тогтмолжуулан төрийн албаны үйл ажиллагааг тасалдуулалгүй сэрэмжтэй ажиллахыг үүрэг болголоо. Мөн тус сумдын Онцгой комисст нэг удаагийн амны хаалт, халуун хэмжигч багаж, түргэвчилсэн оношлуур зэргийг хүлээлгэн өглөө.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүхнийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийг эрчимжүүлэх тухай” А/15 дугаар захирамжийн хүрээнд аймгийн хэмжээнд 17 сум 6

тосгон, аж ахуйн нэгж, байгууллагууд нийт 8052226.68 м2 талбайд ариутгал хийлээ. Тус захирамжаар 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 7 хоногийн баасан гараг бүрт бүх нийтийн ариутгалын ажлыг зохион байгуулах талаар аж ахуйн нэгж, байгууллагуудыг үүрэгжүүллээ.

“Шар Нарст” ХХК нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд Түшиг сумын Эрүүл мэндийн төвд бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн автомашин хүлээлгэн өглөө.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөлөөс Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны Зөвлөл, Орон нутгийн тогтвортой хөгжлийн институттэй хамтран “Төрийн байгууллага, нэгжийн болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах нь”, Монгол Улсын Их сургуультай хамтран “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлага”, Стандарт, хэмжил зүйн газартай хамтран “MNS ISO/PAS 45005:2020, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент-COVID-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа” стандартын тухай цахим сургалтуудыг зохион байгуулж, сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяа агентлагууд, сумдын Засаг даргын Тамгын газрын давхардсан тоогоор 1000 гаруй албан хаагчид хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн ээлжит хуралдаан болж, аймгийн 2020 оны салбарын аваргуудад ирсэн материал, /Ковид-19/ цар тахлын үед тэргүүн эгнээнд ажиллаж байгаа байгууллагуудыг урамшуулах асуудлуудыг хэлэлцэж

- “Аймгийн аварга малчин”-аар 19
- “Аймгийн аварга фермер” –ээр 5
- “Аймгийн аварга тариаланч хамт олон”-оор 4
- “Аймгийн аварга тариаланч”-аар 6
- “Аймгийн аварга ногоочин” –оор 9
- “Аймгийн тэргүүний хамт олон”-оор 2 байгууллага,
- “Салбарын аварга”-аар 14 хүн, Ковид-19 цар тахлын үед идэвх, санаачилга, хариуцлагатай ажилласан 22 байгууллагыг тодруулахаар шийдвэрлэв.

Гал түймрийн гэнэтийн эрсдэлийн улмаас орон гэргүй болсон Алтанбулаг сумын Суварга 2 дугаар багийн өндөр настан Б.Түдэвийн гэр бүлд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гэр олголоо.

“Дэлхийн Зөн Монгол” ОУБ-аас Ерөө сум, Шаамар сумын Дулаанхан тосгоны ерөнхий боловсролын сургуулиудад 450.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Байгаль орчинд ээлтэй орчин үеийн шинэ технологи бүхий ариун цэврийн иж бүрэн байгууламж”-ийг ашиглалтад оруулахад бэлэн болгоод байна.

Аймгийн Онцгой комиссын үйл ажиллагааны талаар:

Аймгийн Онцгой комисс цаг үеийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шуурхай хуралдааныг зохион байгуулж, 5 удаа хуралдаж, аймгийн Онцгой комиссын гишүүд, ажлын хэсгийн дарга нар, сумдын Онцгой комисс, газар, хэлтэс, алба, аж ахуйн нэгж байгууллагуудыг үүрэг чиглэлээр хангаж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай” А/348 дугаар захирамжийн хүрээнд 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажилласан.

“Коронавируст /Ковид-19/-ын халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж, байгууллагуудад дагаж мөрдөх журам”-ын хүрээнд аж ахуйн нэгж,

байгууллагуудад халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэн журмыг мөрдүүлэн ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссоос коронавируст халдвар “Ковид19”-аас урьдчилан сэргийлэх, хамгаалах тандах ажлын хүрээнд Улаанбаатар хотоос сүүлийн 7 хоногт татан авалтаар ирж гэрийн тусгаарлалт, ажиглалтад орсон нийт 888 иргэнийг PCR-ын шинжилгээнд хамруулж хариу нь бүгд сөрөг гарсан.

Сумдаас гарах чиглэлд Улаанбаатар хот бусад аймаг орон нутаг руу 2546 тээврийн хэрэгслээр 5596 иргэн, сум руу орох чиглэлд 1573 тээврийн хэрэгсэлтэй 3930 иргэнийг PCR шинжилгээний хариу, асуумжийг үндэслэн нэвтрүүлсэн.

Сүхбаатар суманд ирсэн 111 иргэний гар утсанд гэрийн ажиглалтад шилжсэн иргэдийн зорчих хөдөлгөөнийг цахимаар хянах “Tracker” системийг суулган хяналт тавин ажиллаж байна.

Авч хэрэгжүүлсэн ажил арга хэмжээ: Аймгийн хэмжээнд нийт голомтын өвчлөлийн 217 иргэн бүгд бүрэн эдгэрч хяналтаас гарсан.

Сүхбаатар суманд коронавируст халдвар /Ковид-19/-ын сүүлийн тохиолдол бүртгэгдсэнээс хойш 44 хоног болж байна.

Батлагдсан 217 тохиолдлын ойрын болон дам хавьтлыг судлах, эцэслэн тогтоох чиглэлээр тандалтын баг, цагдаа, тагнуулын байгууллага хамтран ажиллаж, ойрын хавьтлын нийт 1486, дам хавьтлын 770 иргэн судалгаанд бүртгэгдэж, тусгаарлалт, ажиглалтын хяналтад авч, энэ хугацаанд 3 удаагийн шинжилгээнд хамрагдаж, тусгаарлалтын 14, гэрийн ажиглалтын 14, нийт 28 хоногийн хяналтын хугацаа дуусаж хяналтаас гаргасан.

Аймагт Улаанбаатар хотоос болон бусад аймаг, сумдаас ирсэн 629 өрхийн 1755 иргэн гэрийн тусгаарлалт ажиглалтад байна.

Аймгийн хэмжээнд автозамын шалган нэвтрүүлэх болон хэв журам сахиулах чиглэлээр хяналтын нийт 52 цэг байршилд Цагдаагийн 74, Онцгой байдлын 39, бусад салбарын 45 албан хаагч, 53 нэгж техник хэрэгсэлтэй 24 цагаар үүрэг гүйцэтгэж байна.

Тусгаарлах байрны мэдээ			
д/д	Сумын нэр	Тусгаарлах байр	Тусгаарлагдсан иргэдийн тоо
1	Сүхбаатар	“Сэлэнгэ” зочид буудал	8
2	Ерөө	“Болдтөмөр Ерөө гол” ХХК Баянгол уурхайн тусгаарлах байр	49
Нийт		2	57

Аймгийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргаар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 02 дугаар сарын 01-ний өдөр Ерөө сумын Бугант 3 дугаар баг “Болдтөмөр Ерөө гол” ХХК-ий “Баянголын уурхай”-д үүссэн нөхцөл байдалтай танилцан шуурхай хариу арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

Улаанбаатар хотоос ирсэн уурхайн ээлж солих ажилтнаас “Ковид-19” халдварын PCR шинжилгээний хариу батлагдаж эерэг гарсан тул ХӨСҮТ рүү шилжүүлж, уурхайн байрлалд 49 иргэнийг тусгаарлан ажиглаж байна.

Хилийн боомтуудын үйл ажиллагаа: Алтанбулаг хилийн боомтын орох гарах чиглэлд Улсын Онцгой комиссын шийдвэрээр хөдөлгөөн хийгдэж байна.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2021 оны 02 дугаар сарын 01-ний

өдрөөс эхлэн долоо хоногт 1 өдөр эм, хэрэгсэл, хүнсний бараа ачааг хилээр нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:

Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх, байгууллага аж ахуйн нэгжийн галын аюулгүй байдлыг хангуулах зорилгоор 5 аж ахуйн нэгж байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж, улсын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацаа дууссан 2 аж ахуйн нэгжид хууль тогтоомжийн дагуу үзлэг шалгалт явуулж дүгнэлт олгож, барилга байгууламжийг ашиглалтад авах улсын комисст 1 удаа ажиллаж гал түймэр гамшиг ослоос хамгаалагдсан байдалд хяналт тавьж ажиллалаа.

Улаанбаатар хот болон бусад аймгаас ирж байгаа иргэдийн мэдээллийг улсын Онцгой комисс, аймгийн Онцгой комисст тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.

Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж онцгой байдлын хэлтэс, анги салбаруудад хүргүүлж хяналт тавин ажиллаж байна.

“Adra-Монгол” ОУ-ын хүмүүнлэгийн байгууллагаас аймгийн зорилтод 4 сумын /Орхон, Сайхан, Баянгол, Баруунбүрэн/ 200 өрхөд тус бүр 150 мянган төгрөгийн мөнгөн тусламж олгуулах асуудлыг шийдвэрлүүлсэн.

Объектын гал түймрийн 14 удаагийн дуудлага ирж тухай бүр богино хугацаанд хор уршгийг арилган ажилласан.

Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар:

Засгийн газрын 2020 оны 209 дүгээр “Бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулах тухай” тогтоол, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2020 оны А/146 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд хяналт, шалгалтыг гүйцэтгэлээ.

Аймгийн хэмжээнд 2020 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн голомтын халдваргүйжүүлэлтийг 951 объектод 547662.6 м2 талбайд Зооноз өвчин судлалын төв, Мандал сумын нэгдсэн эмнэлэг голомтын халдваргүйжүүлэлтийг хийхэд хяналт тавьж ажиллалаа.

Мэргэжлийн хяналтын газрын даргын 01/05 удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд хүнсний худалдааны 15, хоол үйлдвэрлэлийн 5, нийт 20 объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийлээ. Шалгалтын явцад 16 зөрчлийг илрүүлж, 9 зөрчлийг арилгуулж, 15 заалттай 1 зөвлөмж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 5 албан шаардлагыг өгч биелэлтийг тооцон ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/348 дугаар “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай” захирамж, аймгийн Онцгой комиссын 2020 оны 03 дугаар “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” албан даалгавар, Улсын Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр “Халдвар хамгааллын дэглэм, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай” албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2021 оны 01/05 дугаар удирдамжийн дагуу Сүхбаатар сумын Баянханы 4 дүгээр багт байрлах “Сүхбаатар хөгжил тохижилт” ОНӨААТҮГ-ын харьяа “Олон улсын худалдааны төв”-ийн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нийт 34 иргэн аж ахуйн нэгж, хүнсний бус худалдаа үйлчилгээ эрхлэгч нийт 56 иргэн, нийт хүнсний болон хүнсний бус худалдаа, үйлчилгээ эрхлэгч 90 иргэнд халдвар хамгааллын дэглэм баримтлан

худалдаа, үйлчилгээ явуулах, халдвар хамгааллын дэглэм баримтлан ажиллаагүй, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй тохиолдолд Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хариуцлага тооцож ажиллахыг сануулж өгсөн үүрэг чиглэлийн дагуу шуурхай хариу арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтанд үүрэг болголоо.

Тус сард нийт 64 вагон 4416 тонн хүнсний улаанбуудайнаас 64 ширхэг дээжийг авч Мэргэжлийн хяналтын газрын Итгэмжлэгдсэн лабораторид чанар аюулгүй байдлыг тодорхойлохоор шинжилгээнд хамруулан ажиллаж байна.

Улсын Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр албан даалгавар, 2021 оны 01 дүгээр хурлын тэмдэглэлийн 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Онцгой комиссын даргын баталсан цахим сургалт хийх тухай хөтөлбөрийн дагуу 17 сум 6 тосгоны Эрүүл мэндийн төвийн 45 эмч, эмнэлгийн ажиллагсад, сумдын байгаль орчны хяналтын 15 улсын байцаагчид нийт 60 албан хаагчдад Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 155 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар тушаал, 2020 оны А/528 дугаар тушаалыг үндэслэн “Тусгаарлан ажиглах байрны халдвар хамгааллын дэглэм”, “Эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдалд анхаарах асуудлууд”, “Сорьц шинжилгээ авах цэгүүдэд ажиллаж буй эмч, эмнэлгийн ажиллагсад халдвар хамгааллын дэглэмд хэрхэн анхаарч ажиллах, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах”, “Сэлэнгэ аймгийн Коронавирусийн өнөөгийн байдал, хариу арга хэмжээ, гэрийн ажиглалт, голомттой бүс нутгаас ирсэн иргэдийг тусгаарлахад анхаарах асуудал” сэдэвт цахим сургалтыг аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулан ажилласан.

Стандартчилал, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:

Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар, Хүдэр, Мандал, Зүүнбүрэн сумын 15 аж ахуй нэгжийн 16 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж тохирлын гэрчилгээ олгосон.

Стандарт, мэдээллийн салбар сангаас 5 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 16 нэрийн 23 стандартаар хангаж, арга зүйн зөвлөмж өгч, дотоод албан хэрэгцээнд 2 нэрийн 2 стандартыг хэвлэн олгосон.

Аймгийн Онцгой комисст “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент, Covid-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа “MNS ISO/PAS 45005:2021” стандартыг үнэ төлбөргүй олгож, 17 сум 6 тосгон, хэлтэс агентлагуудыг дээрх стандартаар хангасан.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр: Сүхбаатар, Алтанбулаг сумын 6 шатахуун түгээх станцын 22 шатахуун түгээгүүр шалган баталгаажууллаа.

Механикийн хэмжлийн төрлөөр: Сүхбаатар суманд худалдаа үйлчилгээ эрхэлдэг иргэдийн 30 жин, авто машины 1 жин, Түшиг сумын 1 иргэний 1 жинг, “Гор Газ” ХХК-ий техникийн 2 термометрийг тус тус шалган баталгаажууллаа.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Өнгөрсөн сард 765 баримтаар 21,801,809,319.5 төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн web сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулж, аймгийн 12 дугаар сарын орлогыг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулсан.

12 дугаар сарын тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт тавьж, 11 дүгээр сарын байдлаар сургуулиудын үдийн цай дотуур байрны хүүхдийн хоолны зардал,

цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмнэлтийн тооцоог хийж Сангийн яаманд 244,7 сая төгрөгийг төвлөрүүлсэн.

2021 оны төсвийн төслийг боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 07 тоот тогтоолоор батлуулсан.

Үндэсний аудитын газраас 2020 оны Их хурлын ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд аудит хийхэд Сонгуулийн тухай хууль зөрчин сонгуулийн зардлын явцын болон эцсийн тайлангаа ирүүлээгүй нэр дэвшигчдэд арга хэмжээ авч ажиллах чиглэл ирсний дагуу 13-р тойрогт нэр дэвшсэн 6 нэр дэвшигчдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчлийн хэрэг нээн ажиллагаа явуулсан.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		104,550,647.9	103,587,353.7	99.1
1.1	Орон нутгийн төсвийн орлого	29,738,788.1	30,019,567.9	100.9
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	20,643,847.9	17,414,633.0	84.4
	Сумдын төсвийн орлого	9,094,940.2	12,604,934.9	138.6
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	5,259,616.5	5,259,616.5	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	56,121,733.1	56,121,733.1	100.0
		590,900.9	590,900.9	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	7,739,532.5	7,739,532.5	100.0
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	1,728,732.9	1,728,732.9	100.0
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	1,418,830.6	1,418,830.6	100.0
1.7	Сум хөгжүүлэх сан /орлого/	1,952,513.3	708,439.2	36.3
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		104,550,647.9	92,217,001.3	88.2
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	104,550,647.9	92,217,001.3	88.2
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	20,996,192.7	16,851,240.6	80.3
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	3,227,414.7	2,258,177.2	70.0
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	16,711,906.0	14,031,830.0	84.0
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	1,854,791.5	1,472,696.0	79.4
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	5,448,448.4	3,848,541.5	70.6
	Халамжийн сан	162,175.0	115,837.9	71.4
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	8,624,139.7	8,219,918.2	95.3
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	622,351.4	374,836.4	60.2
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын	60,257,055.4	55,733,735.4	92.5

	зарлага			
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	3,358,079.1	3,342,018.1	99.5
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		79,061,922.8	76,471,269.8	96.7
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	15,200,657.3	12,610,004.2	83.0
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	2,851,383.3	2,851,383.5	100.0
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	141,343.2	141,343.2	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	
	Хөрөнгө оруулалтын зардалд	2,710,040.1	2,710,040.3	100.0
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	4,888,149.1	4,888,149.0	100.0
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	4,546,992.3	4,546,992.3	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	319,500.0	319,500.0	100.0
	Усан хангамжийн татаас	21,656.8	21,656.8	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	52,838,069.5	52,838,069.5	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	3,283,663.6	3,283,663.6	100.0
3.6	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	56,121,733.1	56,121,733.1	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	30,504,433.6	30,504,433.6	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	16,935,310.5	16,935,310.5	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	7,495,554.6	7,495,554.6	100.0
	- Газрын кадастрын байгууллага	596,303.6	596,303.6	100.0
	- Хүүхдийн байгууллага	590,130.8	590,130.8	100.0
4. Тусгай сангуудын зарлага		1,952,513.3	708,439.2	36.3
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	1,952,513.3	708,439.2	36.3

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2019 12-р сар	2020 12-р сар	<u>2020- 12</u> <u>2019-12</u> Х/төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 166	1 300	111.5

	Талх /орон нутгийн, ш/	1 233	1 316	106.7
	Нарийн боов /кг/	2 466	2 533	102.7
	Будаа /кг/	2 333	2 633	112.9
	Элсэн чихэр /кг/	2 066	2 466	119.4
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	6 500	6800	104.6
	Үхрийн мах /кг/	7 500	7 800	104.0
	Адууны мах /кг/	6500	7 250	111.5
	Ямааны мах /кг/	6 500	6 500	100.0
	Дотор мах, цувдай /цусгүй/	4000	4 000	100.0
	Хиам /чанасан, кг/	10 333	10 666	103.2
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1 200	1 500	125.0
	Сүү / савласан, л/	2 733	3200	117.1
	Тараг /задгай, л/	1 400	1 700	121.4
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	15 000	15 500	103.3
	Айраг /л/	3 500	4 000	114.3
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	7 500	8 650	115.3
	Өндөг /ш/	350	466	133.1
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 800	4 500	118.4
	Өөхөн тос /кг/	2 500	2 500	100.0
	Шар тос /кг/	13 000	15 000	115.4
	Масло /задгай, кг/	4 166	4 500	108.0
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	933	933	100.0
	Лууван /кг/	1166	1 366	117.2
	Манжин /кг/	1666	1 600	96.0
	Байцаа /кг/	1200	1500	125.0
	Сонгино /кг/	1866	2 500	134.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	4 566	4 566	100.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	3000	3 016	100.5
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 750	1 400	80.0
	Бензин А - 92	1 840	1 470	79.9
	Дизелийн түлш	2 470	2090	84.6

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн Засаг даргын 2021 оны “Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” А/07 дугаар захирамжаар Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн зэрэг цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг аймгийн хэмжээнд цахим орчинд тэмдэглэн өнгөрүүлэхээр шийдвэрлэж, Монгол Улсын Үндсэн хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн ач холбогдлыг олон нийтэд сурталчлан, таниулах ажлыг цахим хэлбэрээр зохион байгууллаа.

Мөн аймгийн Засаг даргын 2021 оны “Хүндэтгэл үзүүлэх тухай” А/13 дугаар захирамжаар Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан Монгол Улсын Үндсэн хууль батлалцсан Ардын Их Хурлын 22 депутат болон ар гэрт нь хүндэтгэл үзүүлж нийт 2.2 сая төгрөгийг зарцууллаа.

Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.12 дахь заалтад орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу сумдын ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарыг сумын Засаг даргаас томилж, чөлөөлж байгаатай холбогдуулан /meduuleg.iaas.mn/ цахим системд тэдгээрийн 2020 оны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргуулах сумдын Засаг даргын Тамгын газрын ЭБАТ-д шилжүүлэх нэрсийн жагсаалтыг гарган Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн, сумдын ЭБАТ-д 64 албан тушаалтныг цахимаар шилжүүлж, татан авах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Шинээр 17 сум, 6 тосгоны Соёлын төвийн дарга нарыг нэрсийн жагсаалтад нэмж, цахим системд эрх үүсгэх ажлыг зохион байгууллаа.

ЭБАТ-уудад зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулан, сургалтын материал боловсруулж хөтөлбөрийн салбар ЭБАТ-дад 2021 оны мэдүүлгийн хамрах хүрээ, ХАСХОМ тайлан мэдээ гаргахад анхаарах асуудал зэрэг сэдвүүдээр цахим сургалт зохион байгууллаа.

2020 оны ХАСХОМ гаргах 316 мэдүүлэг гаргагчийн нэрсийн жагсаалтыг аймгийн хэмжээнд гарган нэгтгэж Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн ажилласан.

Цагдаагийн газар: Аймгийн хэмжээнд 01 дүгээр сард 416 холбогдогчтой 1314,6 сая төгрөгийн хохиролтой 557 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 163 хэргээр буюу 22,6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 51,2 хувьтай байгаа нь өмнө оныхоос 3,3 хувиар буурсан байна.

Улсын бүртгэлийн хэлтэс: Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 197, лавлагаа 1 олгож, иргэний бүртгэлийн талаар:

- Төрсний бүртгэл – 220 /эрэгтэй-111, эмэгтэй-109/
- Гэрлэлтийн бүртгэл – 57
- Гэрлэлт цуцалсны бүртгэл – 4
- Үрчлэлт - 4
- Эцэг тогтоолт – 5
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 6
- Нас баралт – 73
- Нийт олгосон иргэний үнэмлэх – 444
- Шинээр олгосон иргэний үнэмлэх – 147
- Дахин олгосон иргэний үнэмлэх – 39
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусаж солиулсан – 258
- Гадаад паспорт олголт – 9
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн – 195
- Хот доторх шилжилт хөдөлгөөн – 369 тус тус бүртгэгдсэн байна.

“Төрийн архивын барилгын зураг, төсөв хийлгэх ажлын хэсэг байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2021 оны А/21 дүгээр захирамжийг батлуулсан.

Архивын баримтыг цахимжуулах ажлын төлөвлөгөөний хүрээнд 1 хөмрөгийн 4 хадгаламжийн нэгжийн 467 хуудас баримтыг цахимжууллаа.

Ардын хувьсгалын 100, аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг угтан зохион байгуулах арга хэмжээний хүрээнд Сэлэнгэ аймгийн түүхэнд холбогдох баримтуудыг олон нийтэд сурталчлах ажлыг эхлүүлж, Үндэсний төв архиваас Сэлэнгэ аймагт холбогдох 1931 оны мэдээллийг хуулбарлан авч хөрвүүлэн холбогдох хэлтэст

шилжүүлэн өгсөн. Мөн 1945 онд явагдсан Бүх нийтийн санал асуулга явуулсан тухай аймгийн комиссын тайлан мэдээ болон “Сэлэнгэ аймаг байгуулах тухай” Бүгд найрамдах Монгол Ард улсын Их хурлын Тэргүүлэгчдийн 1959 оны зарлигийн хуулбарыг Үндэсний төв архиваас татан авч нийтлүүлэхэд бэлэн болгож ажиллалаа.

Иргэдийн гаргасан хүсэлтийн дагуу 261 архивын лавлагаа цахим болон цаасан суурьтай баримтаас гарган өгч үйлчилсэн.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1. Боловсрол, соёл урлаг, спортын талаар:

2020-2021 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа малчин өрхийн нийт 3018 сурагч байгаа бөгөөд тэдгээрийн 1879/62.2 хувь/, цэцэрлэгт явж байгаа малчин өрхийн 846 хүүхдийн 450/53.1 хувь/ нь теле хичээлээ үзэж чадахгүй байгаа гэсэн судалгаа гарсан. Судалгааны санал асуулгад сурагчдын бичсэн нийтлэг шалгаан нь “Өвлийн улирал эхэлж өдөр бүр бүрхэг байгаагаас нарны үүсгүүр гүйцэд цэнэглэгдээгүй тул”, “Зурагт гарахгүй, ДДШ антен байхгүй, зурагт шатсан”, “Теле хичээл гарах цагт нь амжаагүй учраас нөхөж үзэх боломж байхгүй”, “Дүү нарын хичээлтэй давхацсан учраас үзээгүй”, “Сонирхолгүй учраас теле хичээлээ үзээгүй” гэх мэт шалтгаануудыг дурдсан бөгөөд сурлагын хоцрогдол гаргахгүйн тулд теле хичээлээ үзэж чадахгүй байгаа эдгээр сурагчидтай эгэх холбоо тогтоон хамтран ажиллаж сургуулийн өмнөх боловсролын багш нар тухайн хүүхдийнхээ зурагтай хэвлэмэл дасгал даалгаврыг амин дэмийн хамт хүргүүлэх, зарим сум, сургуулийн бага ангийн багш нар “Эцэг эхтэй харилцах дэвтэр”, “Даалгаврын богц” аялуулах, талархлын захидал, дасгал даалгавруудыг дэлгүүрт үлдээх, сумын Онцгой комисс, мал тооллогын ажлын хэсгээр дамжуулан малчин өрхөд хүргүүлэх зэрэг олон хэлбэрээр сурагч, эцэг эхчүүдтэй хамтран ажиллаж байна.

Малчид өвөлжилтийн нөхцөл байдлаас хамаарч отроор өөр аймаг, сумын нутагт байх тохиолдолд аймаг, сум хооронд мэдээлэл солилцон, менежмент, зохицуулалт хийж ажиллахыг Боловсролын хүрээлэнгээс зөвлөмжийн дагуу хэвлэмэл материал боловсруулах талаар 17 сум 6 тосгодын багш нарт зөвлөгөө өгч, боловсруулсан материалыг сурагчдад хэрхэн хүргэж ажиллаж байгаа талаар судалгаа авахаар бэлтгэл ханган ажиллаж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэгдэж буй багш, сурагч, эцэг эх, олон нийтэд зориулсан контент, интерактив хичээлийг үзэхийг эцэг эх, сурагч, олон нийтэд сануулж, мэдээллийг сургууль, цэцэрлэгийн удирдлагын цахим группээр дамжуулан тогтмол хүргэж байна.

Боловсролын хүрээлэнгээс зохион байгуулсан “Сурагчдын амралтын үеийн сургалтын хөтөлбөрийг дэмжих үйл ажиллагаа” онлайн хэлэлцүүлэгт оролцож, сайн туршлагаа бусад аймгуудад хуваалцаж ажиллалаа.

Боловсрол шинжлэх ухааны яамнаас төрийн өмчийн цэцэрлэгийн удирдах ажилтанд зориулсан “Цэцэрлэгийн менежмент, манлайлал” сэдэвт цахим сургалтыг төрийн өмчийн 38 цэцэрлэгийн эрхлэгчид зохион байгуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна.

“Цахимаар хүүхдүүдээ хэрхэн хөгжүүлэх вэ?, Гэр бүлийн орчинд хүүхдүүдээ хэрхэн хамгаалах вэ? Сэдэвт сургууль, цэцэрлэгийн багш нарт зориулсан цахим сургалтыг “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын Сэлэнгэ ОНХХ-тэй хамтран зохион байгуулж, “Хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөр”-ийн танилцуулга сургалтыг зохион байгуулах бэлтгэлийг хангаад байна.

Боловсрол шинжлэх ухааны яамны санхүү эдийн засгийн газраас 21 аймаг 9 дүүргийн БСУГ-ын дарга, төсвийн мэргэжилтэн нарт цахим хэлбэрээр онлайн хурал хэлэлцүүлэг хийж 2021 оны төсвийн чиглэл, тулгамдаж буй асуудал, цаашид хийж гүйцэтгэх ажлын талаар чиглэл өгч санал солилцлоо.

Боловсролын хүрээлэнгээс зохион байгуулсан “Сурагчдын сурах үйлийн тулгамдаж буй асуудал, эцэг эхийн дэмжлэг” хэлэлцүүлэгт дунд, ахлах ангийн 200 сурагчийг оролцуулсан ба шууд дамжуулалтыг сурагчдад үзүүлэх, үе шаттай зохион байгуулж байгаа хэлэлцүүлэгт 7 хоног бүр суралцагчдыг оролцуулан ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын 2021 оны эхний хурлыг зохион байгуулж нийт 54 хүүхдийн материалтай танилцаж, шинээр асаргаанд орсон 3 хүүхдийн хувийн хэргийг нээн эцэг эхтэй утсаар холбогдон гэрийн нөхцөлд хүүхдэд тавьж буй анхаарал халамж, хөгжлийн асуудлаар ярилцан зөвлөгөөг өгч ажиллалаа.

Газарзүйн багш нарт цахим хичээл бэлтгэх, туршлага, арга зүйгээ солилцох 2 удаагийн онлайн сургалтыг зохион байгууллаа. Сургалтад нийт 25 багш хамрагдаж, харилцан туршлага хуваалцаж зөвлөгөө өгч хамтран ажиллалаа.

БШУЯ-ны Тусгай хэрэгцээт боловсролын хэлтсээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тулгарч буй бэрхшээл болон тэдний хэрэгцээг судлах судалгааг 30 эцэг эх, 20 хүүхдээс авч цахимаар хүргүүлэн ажиллалаа.

Соёлын яамнаас уриалсан “Цахим орчинд соёл түгээе, би хариуцлагатай иргэн” уриан дор аймгийн Нэгдсэн музейн сан хөмрөгөөс 11 ширхэг үзмэрийг олон нийтийн танин мэдэхүйн юунд зориулан цахим орчноор дамжуулан нийтийн хүртээл болголоо.

Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Хуруу хүүхэлдэй хийж бүтээцгээе”, “Музейгээр аялсан дурсамж” зэрэг баримлын шавран бүтээл, гар зургийн уралдааныг зохион байгуулж 120 сурагч хамрагдан шалгарсан бүтээлүүдийн шагналыг шуудангаар хүргүүлэн ажиллалаа.

2. Эрүүл мэндийн талаар:

Коронавирусийн халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдах судалгааг аймгийн Онцгой комисстой хамтран зохион байгуулж 30000 гаруй мянган иргэний судалгааг гарган “Халдварт өвчин судлалын үндэсний төв”-д хүргүүлсэн. Коронавирусийн халдварын эсрэг дархлаажуулалтыг зохион байгуулах хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газраас дархлаажуулалтын кабинет, хүний нөөцийн бэлэн байдал, тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж дээр хяналт үнэлгээ хийгдэж байна.

Коронавирусийн халдварын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, эмчилгээ, оношилгоо, хариу арга хэмжээний талаарх сургалтыг 17 сум 6 тосгонд цахим хэлбэрээр зохион байгуулж 80 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан.

Эрүүл мэндийн яамны захиалгаар “Дэлхийн эрүүл мэндийн байгууллага”-ын арга зүйн дэмжлэгтэйгээр “Шинэ коронавируст халдварын тархвар зүйн хүн амын насны бүлэгт суурилсан” судалгааг “Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургууль”-тай хамтран Сүхбаатар, Алтанбулаг, Хушаат сумын 300 иргэдийн дунд хийсэн.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын үеийн хүний нөөцийн бэлэн байдлыг ханган, шуурхай хариу арга хэмжээ авах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрчимжүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн хөгжлийн төв”-тэй хамтран “Хамгаалах хувцас хэрэгслийг зөв өмсөж, аюулгүй тайлах” сэдэвт цахим сургалтыг аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан зэрэг 120 гаруй хүнийг хамруулан зохион байгууллаа.

3. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд:

Халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь олгох ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд “Халамжийн сан”-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргаж аймгийн Төрийн Аудитын газар хүргүүлсэн.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй чанартай хүргэх, халамжийн шинэ үйлчилгээг нэвтрүүлэхэд төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор 17 сум 6 тосгонд мэргэшиж, дадлагажсан 35 мэргэжилтнүүдээр төрийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд халамжийн санд улсын төсвөөс 11073 иргэнд 1203396.5 мянган төгрөгийг зарцууллаа. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2257 иргэнд 645476.9 мянган төгрөг
- Нийгмийн халамжийн тэтгэмжид 1568 иргэнд 139896.9 мянган төгрөг
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 1487 иргэнд 145471.6 мянган төгрөг
- Жирэмсэн эхийн тэтгэмжид 751 эхэд 27704.5 мянган төгрөг
- 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 4821 эхэд 233510.7 мянган төгрөг
- Ахмадын настанд олгох хөнгөлөлт, тусламжид 30 ахмадын 4556.0 мянган төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжид 159 иргэний 6779.6 мянган төгрөг
- Хүнсний эрхийн бичгийн 5318 иргэнд 63088.0 мянган төгрөгийг тус тус зарцууллаа.

Иргэдэд Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, иргэдийг ажилд зуучлах хүрээнд 2020 оны 12-р сарын 25-ны байдлаар бүртгэлтэй ажилгүй 619 иргэн байсан бол 25 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 9 ажлын байранд 9 хүнийг ажилд зуучилж, идэвхгүйн улмаас 10 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 625 болсон байна.

4. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

Аймгийн хэмжээнд архины хамааралтай 276 өрхийн 308 хүүхдэд хяналт тавин ажиллаж “Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги”-ийн хамтарсан баг архины хамааралтай гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй, өндөр эрсдэлтэй 3 өрхийн 7 хүүхдийг байнгын хяналтад авч, өрх толгойлсон 1 эмэгтэйн 3 хүүхдийг ойрын хамаатны асрамжид өгч, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт холбон зуучилсан.

Азийн хөгжлийн банк, “Монгол өрх” сэтгэл зүйн хүрээлэнгийн мэргэжлийн зөвлөлтэй хамтран, “Зан үйл өөрчлөх мэдээлэл харилцааны төсөл”-ийг гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдлэг, хандлага, зан үйлийн төлөв байдлыг үнэлэх түргэвчилсэн үнэлгээг зорилтот гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан 5 эмэгтэй, хүчирхийллийн асуудлаар мэдээлэгдэж байсан 5 эрэгтэй, 5 өсвөр насны охид, 5 өсвөр насны хөвгүүд, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг 5 мэргэжилтнээс тус бүр ганцаарчилсан ярилцлага болон энэ ангиллын 5 бүлгээр фокус бүлгийн ярилцлагыг авч нэгтэн хүргүүлэн нийт 25 хүнийг хамруулан ажиллалаа.

“Ковид-19” цар тахлын эсрэг хорио цээрийн дэглэмийн үед залуучуудын хөгжил, хамгаалал, оролцоог дэмжих бодлого, арга хэмжээний хүрээнд:

1. Орой бүр хүүхдүүддээ үлгэр уншиж өгч байхыг уриалж аймгийн хэмжээнд “Үлгэрч аав ээж” фото зургийн уралдааныг зохион байгуулж, нийт 14 гэр бүл оролцож эхний 2 байрыг шалгаруулан, байр эзэлсэн аав ээжид гэр бүлийн уран сайхны зураг авахуулах эрхийн бичгээр шагналаа.

2. Аймгийн хэмжээнд “Хөл хорио ба Сэтгэл зүй”, “Миний мэргэжил миний гарт”, “Оюутны ширээнээс амжилтын ширээ” сэдвүүдээр цахим сургалт зохион байгуулж, нийт 9231 өсвөр үе, залуучууд хамрагдан санаа бодлоо солилцлоо.
3. “Залуусаа сонсьё”, “Залуусын оролцоо, бүтээлч залуус” сэдэвт цахим уулзалтаар 17 сумын залуучуудын элч, “Calm”, “Хараа нутгийн хөгжлийн элч” залуус, “Эерэг өөрчлөлтийг хамтдаа”, “Хөгжлийн хүч Залуусын нэгдэл” зэрэг төрийн бус байгууллагуудын залуучууд санаа бодлоо илэрхийллээ. Үүнд:
 - Залуучуудын элчийг салбар зөвлөлд оруулах
 - Залуучуудын үйл ажиллагаа хүртээмжийг нэмэгдүүлэх
 - Сонирхлын бүлгүүдийг бий болгон дэмжин ажиллах
 - Хогийн асуудлыг анхаарах
 - Мод тарих аяныг өрнүүлэх
 - Залуучуудын чуулга уулзалт хийх
 - Залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний 100 жил, Ардын хувьсгалын 100 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг угтан олон нийтийн ажил өрнүүлэх
 - Оюутан залуусын дунд эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулах, 2021 онд хийж гүйцэтгэх дээрх саналуудыг дэвшүүллээ.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

1. Мал эмнэлгийн үйлчилгээний талаар:

Мал амьтны шилжилт хөдөлгөөн, харьяалалгүй малын судалгааг авахад аймгийн хэмжээнд 8 сумын нутаг дэвсгэрт Өвөрхангай, Төв, Баянхонгор, Улаанбаатар, Булган, Говь-Алтай, Орхон, Дундговь, Хэнтий, Дархан-Уул зэрэг 11 аймгаас 5113 адуу, 4098 үхэр, 36725 хонь, 21109 ямаа нийт 67645 толгой мал отор нүүдлээр шилжин ирж өвөлжиж байна.

Тус сард хүнсэнд 413 мал эмнэлгийн гэрчилгээг бичигдэж, адуу 78, үхэр 193, хонь 960, ямаа 837, тэмээ 1 бүгд 2069 толгой мал амьтан эдийн засгийн эргэлтэд орсон байна.

Шимэгчтэх, халдваргүй өвчний сарын мэдээг 17 сумаас авч, шимэгчтэх өвчнөөр өвчилсөн 8351, үхсэн 1, эдгэрсэн 8350 мал, амьтан халдваргүй өвчнөөр өвчилсөн 205 үүнээс үхсэн 17 эдгэрсэн 188 мал, амьтан өвчилж эдгэрсэн байна. Сүхбаатар сумын хэмжээнд хүнсний зах дэлгүүрт худалдан борлуулж байгаа мах, махан бүтээгдэхүүний 4200 кг үхрийн махны 35 дээж, 840 кг хонины махны 40 дээж, 540 кг ямааны 27 дээж, 840 кг адууны махны 7 дээж, сүү, сүүн бүтээгдэхүүний 140 л сүү, 130 л тараг, 120 кг ааруул, 80 кг эзгий, 90 кг өрөм, 40 кг цөцгийн тосноос ариун цэврийн магадлан шинжилгээг стандарт арга зүйн дагуу хийж гүйцэтгэсэн.

“Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх нь” төслийн зөвлөх үйлчилгээний баг нь НҮБ-ын ХХААБ-ын “Лаборатори үнэлэх арга” (FAO LMT) болон Олон Улсын стандартад нийцүүлэнманай лабораторид цахимаар ерөнхий үнэлгээ хийж шаардлагатай зарим мэдээлэл, баримт бичиг, гэрэл зургийг цахим шуудангаар явуулсан.

2. Хөдөө аж ахуйн талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоолоор улсын хэмжээнд коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Улсын онцгой комиссын даргын 2020 оны

“Хүнсний хангамжийн удирдлагын шуурхай штаб байгуулах тухай” 21 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны “Хүнсний хангамж, нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах тухай” А/309 тоот захирамжийг сумдад хүргүүлэн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, аймаг орон нутгийн иргэдийг хүнсний бүтээгдэхүүнээр хангах, нөөц бүрдүүлэлт, дэлгүүрүүдийн борлуулалтын мэдээг өдөр тутам авч, төмс, хүнсний ногооны нөөцийн мэдээг 14 хоногт 1 удаа авч, 17 сумын 210 иргэн, аж ахуй нэгжийн нөөцийн мэдээг нэгтэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэн ажиллаж байна.

2021 онд 193,3 мянган га талбайд буюу үр тариа 163,2 мянган га талбайд, тосны ургамал 16,1 мянган га талбайд, тэжээл 8,6 мянган га талбайд, төмс 2722 га-д, хүнсний ногоо 2739 га талбайд тус тус тариалах төлөвлөгөөг гаргаад байна.

Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Хоршоолсон хэлбэрээр хүнсний ногоо эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах 9192-Мон” төслийн хүрээнд байгуулж буй 4 улирлын хүлэмжийн ажлын явцын гүйцэтгэлийг хүлээн авах ажлаар ХХААХҮЯ, ХХААГ-ын ажлын хэсэг Ерөө суманд ажиллалаа. Ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.

“Улс, аймгийн аварга тариаланч хамт олон” 5, “Улс, аймгийн аварга тариаланч” 5, “Улс, аймгийн аварга ногоочин” 2, тус тус нийтдээ 12 материалыг сумдаас цахимаар авч Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэн ажиллалаа.

2020 оны жилийн эцсийн мал тооллогын нэгдсэн дүнгээр 5211 малчин, 4783 мал бүхий өрх, 69 аж ахуйн нэгжид 1818519 толгой мал тоологдсон. Төрлөөр нь авч үзвэл 0.4 мянган тэмээ, 109.7 мянган адуу, 256.0 мянган үхэр, 783.4 мянган хонь, 669.0 мянган ямаа тоологдов. Малын нийт тоо өмнөх оноос 136.0 мянга (8.1 хувь) үүнээс адуу 6.3 мянга (6.1 хувь), үхэр 23.7 мянга (10.2 хувь), хонь 38.7 мянга (5.2 хувь), ямаа 67.4 мянга (11.2 хувь)-иар тус тус өсөж, тэмээ 43 (9.1 хувь) толгойгоор буурсан байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар шувуу 12459, гахай 4069, зөгийн бүл 6081 тоологдсоныг 2019 оны мөн үетэй харьцуулахад шувуу 159 (1.3 хувь) толгой, гахай 985 (31.9 хувь) толгой, зөгий 599 (10.9 хувь) бүлээр тус тус өссөн байна.

2020 онд үндэсний боловсруулах үйлдвэрт бод богийн арьс тушаасан малчдын урамшууллын материалыг хүлээн авч мэдээллийн санд тулгалт хийж оруулах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

3. Байгаль орчны талаар:

Баруунбүрэн, Жавхлант, Мандал, Орхонтуул, Сайхан, Сант зэрэг сумдын ойжуулах талбайн судалгааг үндэслэн талбайн хэмжээ, байршлыг тодорхойлон аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

“Гербераа” ХХК нь Ерөө суманд шатахуун түгээх станц /ШТС/-ын үйл ажиллагаа явуулахаар байгаль орчинд, нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулсан.

“Алт” хөтөлбөр, “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр”, “Ногоон хөгжлийн бодлого”, “Ус” үндэсний хөтөлбөрийн биелэлтийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллалаа.

4. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар:

Сүхбаатар сумын Боргүвээ 5-р багт 4 нэгж талбар, Баянхан 4-р баг 6 нэгж талбар, Салхит 3-р багт 2 нэгж талбарыг хаягжуулалтын журмын дагуу дугаарлан, Хонгор морьт 1-р багт 10 нэгж талбарт нэр өгч аймгийн мэдээллийн санд бүртгэн ажиллалаа.

Мандал, Баянгол, Сайхан, Шаамар, Сүхбаатар сумдын шатахуун түгээх станцуудын мэдээллийг 192.168.10.37 серверт баяжуулж ажилласан. “Хаягийн мэдээллийн систем байгуулах төсөл, арга хэмжээг эрчимжүүлэх” ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 4247 нэгж талбар, 2316 барилга, 1754 гудамжийг баталгаажуулж, 26 иргэнд шинэчилсэн хаягаар кадастрын зураг хэвлэж, 8 өмчлөлийн эрх шилжилтийг тус тус бүртгэн ажилласан.

Аймгийн хэмжээнд 4115263.00 га газар улсын тусгай хэрэгцээнд авсан байна.

5. Орон нутгийн өмчийн талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 25 дугаар тогтоолын дагуу Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг аймгийн хэмжээнд 9 сумын 9 төсөвт байгууллага нь өөрийн эзэмшлийн барилга байгууламж бусад үндсэн хөрөнгийг түрээслүүлэн ажиллаж байна. Түрээслэгч, түрээслүүлэгчийн хооронд түрээсийн гурвалсан гэрээг батлагдсан зааврын дагуу баталгаажуулан гэрээний биелэлтэд хяналт тавьж ажилласан. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээсээр ашиглаж буй этгээдийн түрээсийн төлбөр нь 4-р улирлын байдлаар 20,1 сая төгрөгийн орлогоос 20 хувь болох 4,1 сая төгрөг, дуудлага худалдааны орлогоос 7,1 сая төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажилласан.

2021 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д 1 агентлаг, 14 сум, 6 сургууль цэцэрлэгийн төлөвлөгөөг хянан баталгаажуулж Сангийн яаманд илгээж батлуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны бараа, ажил, үйлчилгээний 8,153.6 сая төгрөгийн 69 төсөл арга хэмжээний төлөвлөгөөг 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдөр батлуулж Орон нутгийн өмчийн газрын 2020-12-15 өдрийн 482 тоот албан бичгээр Сангийн яаманд төлөвлөгөөг хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллалаа.

6. Ус, цаг уур, байгаль орчны хяналт судалгааны мэдээ мэдээлэл:

Бүх сумдын нутгаар 0-15 см зузаан цасан бүрхүүл тогтсон бол хамгийн их нь Хүдэр, Бугант сумдын нутгаар 10-15 см бөгөөд бусад сумдын нутгаар 0-7 см цасан бүрхүүлтэй байна. Цагааннуур, Зэлтэр, Хүдэр, Бугант сумын нутгаар цасны зузаан 5-15 см, цасны нягт 0,11-0,16 г/см³, бусад сумдын нутгаар цасны зузаан 1-4 см байна.

Сэлэнгэ мөрөн Зүүнбүрэн сум орчмоор мөсөн бүрхүүл, харзтай, мөсний зузаан 97 см ОЖД-аас 9 см-ээр их, Сүхбаатар сум орчим мөсөн бүрхүүл, харзтай, мөсний зузаан 70 см, Орхон гол Орхон сум орчмоор битүү мөсөн бүрхүүлтэй, мөсний зузаан 89 см ОЖД-аас 7 см-ээр их, Сүхбаатар сум орчмоор битүү мөсөн бүрхүүл, мөсний зузаан 68 см ОЖД-аас 1 см-ээр бага, Ерөө гол Бугант тосгон орчим битүү мөсөн бүрхүүл, мөсний зузаан 78 см ОЖД-аас 14 см-ээр бага, Ерөө сум орчмоор битүү мөсөн бүрхүүл, мөсний зузаан 81 см ОЖД-аас 11 см-ээр бага, Дулаанхан сумаар битүү мөсөн бүрхүүл, мөсний зузаан 85 см ОЖД-аас 7 см-ээр бага, Хараа гол Баянгол сум орчмоор битүү мөсөн бүрхүүл, мөсний зузаан 55 см ОЖД-аас 11 см-ээр бага, Хүдэр гол Хүдэр сумаар битүү мөсөн бүрхүүл, мөсний зузаан 67 см ОЖД-аас 7 см-ээр их, Зэлтэр гол Түшиг сум орчим мөсөн бүрхүүл харз, мөсний зузаан 65 см ОЖД-аас 23 см-ээр их байна.

Ихэнх хугацаанд агаарын температур шөнөдөө 28-33 градус, өдөртөө 18-23 градус хүйтэн байлаа.

Сүхбаатар сумын агаарын чанарын харуулын ажиглалтын дүнгээс үзэхэд агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 0.009 мг/м³, хамгийн их нь 0.013 мг/м³, азотын давхар ислийн дундаж агууламж 0.021 мг/м³, хамгийн их нь 0.031 мг/м³, нийт тоосны

дундаж агууламж 0.156 мг/м³, хамгийн их нь 0.431 мг/м³ байна. Агаарын чанарын MNS 4585:2016 стандарт дахь хүлцэх агууламжаас PM10 тоосонцор 2021.01.11-нд 1.58 дахин, 2021.01.14-нд 2.79 дахин 2021.01.18-нд 2.43 дахин давсан байна. Агаар болон хөрсөн дээрх цацрагийн түвшин фон төвшнөөс даваагүй байна.

Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид танхимаар нэг удаа хуралдаж

1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дэг батлах тухай
2. Ажлын хэсэг байгуулах тухай
3. Өргөдөл гомдол хууль хяналтын бодлогын хорооны дүгнэлтийг хэлэлцэх тухай
4. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны ажлын төлөвлөгөө боловсруулах тухай
5. Шагналд тодорхойлох тухай зэрэг 5 асуудлыг хэлэлцсэн.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/348 тоот, сумын Засаг даргын 2021 оны А/01 тоот “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай” захирамжийн дагуу автозамын 1 хяналтын цэг, сумын төвийн иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах хариуцлагатай эргүүл жижүүр, сумын шуурхай штабт төр, төсвийн байгууллагын 68 албан хаагчид үүрэг гүйцэтгэж байна.

2021 оны аймгийн Онцгой комиссын нарийн бичгийн даргын 102 тоот албан бичгийн дагуу Улаанбаатар хотод хөл хорионд орсон 49 иргэнийг татан авч гэрийн ажиглалтад авч, хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Төрийн байгууллага, нэгжийн болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах тайлагнах” сургалт, “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлага” сургалтад төр, төсвийн байгууллагын 40 албан хаагч хамрагдсан.

Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/06 тоот “Халдварт саагийн эсрэг идэвхжүүлсэн вакцинаар дархлаажуулах тухай” тушаалаар зорилтот 87 хүүхдийг нэмэлт саагийн вакцинд хамруулсан.

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл, сорьц бэлтгэх, тээвэрлэх заавар” сэдэвт 4 удаагийн цахим сургалтад Эрүүл мэндийн төвийн 23 эмч, ажилчид хамрагдсан.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/15 тоот “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийг эрчимжүүлэх тухай” захирамжийн дагуу Коронавирусын халдвар /Covid-19/-ын тархалтыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах зорилгоор бүх нийтийн ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж, 16 албан байгууллагын 5457 м², худалдаа үйлчилгээний 19 дэлгүүрийн 825 м², 64 айлын орц, подволь, замын пост 2078 м², сумын хэмжээнд нийт 8357 м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл цахимаар явагдаж байгаатай холбогдуулан сургуулийн багш ажилчдын дунд “Хөл хорисон ч хөгжих эрх нээлттэй” уралдааны 2 дугаар шатны хүрээнд “Гэрийн сайн эзэгтэй” тэмцээнийг зохион байгуулж, тэмцээнд 14 багш, ажилтан оролцож шагналт байруудыг тодруулж ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургуулийн 815 сурагч, цэцэрлэгийн насны 310 хүүхэд өдөр бүр цахим болон теле хичээлд хамрагдаж байна.

Боловсрол соёл урлагийн газраас энэ сарын 14-21-ний өдрүүдэд зохион байгуулсан “Чадварлаг багш”, Монгол Улсын хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого зэрэг сургалтад сумын 1, 2, 3 дугаар цэцэрлэгийн 6 багш, ажилтан хамрагдсан.

Баруунбүрэн сүм:

“Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж суманд Улаанбаатар хот болон бусад аймаг сумаас ирсэн иргэдийг 14 хоногийн гэрийн тусгаарлалтад оруулан, хяналт тавин ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2021 оны “Халдвар хамгааллын дэглэм, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай” А/02 тоот захирамжаар сумын хэмжээнд хариуцлагатай эргүүл жижүүрүүдийг ажиллуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Монгол улсын Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” А/07 тоот захирамжийн хүрээнд цахим хуудсаар сургалт сурталчилгаа зохион байгуулан ажиллалаа.

Ерөнхий боловсролын Багш нарын дунд “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт /Танхимын ба цахим хичээл/ асуудал шийдэл” сэдэвт илтгэлийн уралдаанд 27 багш, боловсролын хүрээлэнгээс зохион явуулсан “Суралцагчдын сурах үйлийн тулгамдаж буй асуудал, эцэг эхийн дэмжлэг” хэлэлцүүлэгт дунд, ахлан ангийн 98 суралцагч хамрагдсан.

Суралцагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэх ажлын хүрээнд цахимаар

- “Дархлаагаа дэмжье” тик-ток уралдаанд 6-12-р ангийн 6 суралцагч,
- “Англи хэлээр өөрийгөө танилцуулъя” сэдэвт уралдаанд ахлах ангийн 6 суралцагч,
- “Үндсэн хуулийн өдөр”-ийг тохиолдуулан ахлан ангийн суралцагчдын дунд “Монгол Улсын үндсэн хууль ард түмний үнэт зүйл” эссэ уралдааныг зохиож 16 суралцагч тус тус оролцлоо.
- Гадаадын их дээд сургуульд суралцаж буй монгол оюутнуудтай Zoom meeting апп-ээр ахлах ангийн 6 суралцагч холбогдон тэтгэлэгт хөтөлбөрт хэрхэн хамрагдах, гадаадын их сургуулиудын онцлог, хэрхэн амжилттай сурах талаар тодорхой ойлголтуудыг мэдэж авлаа.

Спорт цогцолбороос цахим орчинд эрүүл мэндийн зөвлөгөө, спорттой холбоотой танин мэдэхүйн болон сүүлийн үеийн мэдээ мэдээлэл, ковид-19 цар тахалтай холбоотой зөвлөмж анхааруулга, нутгийн бөхчүүдийн товч намтар амжилт, дархлаа дэмжих дасгал хөдөлгөөн гэх мэт нийт 28 удаагийн мэдээлэл оруулж иргэдэд мэдээлэл хүргэн ажиллаж байна.

“КОВИД-19” цар тахлын үед ард иргэдийн дархлааг дэмжих, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Гэр гэртээ дасгалаа хийе” цахим уралдааныг зохион байгуулан ажиллалаа.

Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/06 тоот “Халдварт саагийн эсрэг идэвхжүүлсэн вакцинаар дархлаажуулах тухай” тушаалаар зорилтот хүүхдүүдийг нэмэлт саагийн вакцинд хамруулсан.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай”, сумын Засаг даргын 2021 оны “Халдвар хамгааллын дэглэм,

ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай” А/02 тоот захирамжуудын хэрэгжилтийг ханган ажиллаж төр, төсвийн байгууллагууд ариутгал халдваргүйжүүлэлтийг зохион байгуулж, айл өрхүүд гэр гэртээ цэвэрлэгээг хийж 9 байгууллагын нийт 9048 м2 талбайд хийлээ.

Коронавирусийн халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд улс, аймаг, сумын Онцгой комиссын болон холбогдох дээд шатны байгууллагуудаас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг ханган, ард иргэдэд зөвлөгөө, зөвлөмж, мэдээллийг цахим болон тараах материалаар тогтмол хүргэн ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2020 оны 12-р сарын 17-ны “Мал тэжээвэр амьтад, хашаа, худгийн ээлжит тооллого зохион байгуулах тухай” /171 дүгээр захирамж жилийн эцсийн мал тооллогоор сумын хэмжээнд малын тоо толгой 5 төрөл дээр өссөн дүнтэй байна. Төрлөөр нь авч үзвэл тэмээ 4, адуу 667, үхэр 1806, хонь 4922, ямаа 5953 толгой буюу нийт 13352 толгой буюу 7.7 хувиар өссөн байна.

Баянгол сум:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 238 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/15 тоот захирамжийг сум орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн Улс, аймгийн Онцгой комиссоос ирүүлсэн заавар зөвлөмжийг удирдлага болгон ажиллаж байна.

Сумын хэмжээнд Цагдаагийн хэсэг, Гал түймэр унтраах 40-р анги, Улсын нөөц, хүмүүнлэг тусламжийн анги, Ерөнхий боловсролын сургууль, Баянгол цэцэрлэг, Засаг даргын Тамгын газар хамтран 24 цагийн пост 2 цэгт 4 албан хаагч үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А\348 дугаар захирамжийг дагуу Архи согтууруулах ундаа, худалдах, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж байгууллагуудтанилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2020 оны Шуурхай штаб байгуулж ажлын тусгай горимд шилжүүлэх тухай А\254 дүгээр захирамжийн дагуу Засаг даргын Тамгын газрын байранд шуурхай штабыг байрлуулан 24 цагийн хариуцлагатай жижүүрийг томилж, үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээ, мэдээллийг аймгийн Онцгой комисс болон холбогдох байгууллагад 99561654 дугаарын утсаар болон цахимаар буюу Bayangol.ontsgoi.komiss@gmail.com хаягаар хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/15 захирамжийн дагуу сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төр төсвийн байгууллагууд нийт 7770 м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 194 дүгээр тогтоолын хавсралтад заагдсан хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны жагсаалтад багтсан шалтгаанаар 130 иргэний хүсэлтийг шийдвэрлэж, бусад сум орон нутгаас зорчин ирсэн 18 иргэн тэдгээрийн гэр бүл болон 13 өрхийн 36 иргэн гэрийн тусгаарлалт ажиглалтад аваад байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/04 тоот захирамжийн дагуу 18-50 насны эрчүүд, дээд офицер, ахлах офицер, эмэгтэй офицер, ахлагч, байлдагч, түрүүч болон цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүдийн бүртгэлд хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Сум орон нутагтаа ажил үйлсээрээ тэргүүний иргэдийг төрийн дээд шагналд тодорхойлон Хөдөлмөрийн Гавьяаны Улаан тугийн одонгоор 6, Алтангадас одонгоор

29, Хөдөлмөрийн Хүндэт медалиар 25, Цэргийн гавьяаны одонгоо 2, Салбарын тэргүүнээр 2 нийт 64 иргэнийг шагнуулахаар холбогдох материалыг бүрдүүлэн дээд шатны байгууллагад уламжлан ажилласан.

Arplus.mn сайтаар 8-10, 11-12-р ангийн суралцагчдад хуваарийн дагуу байгалийн ухаан, гадаад хэлний чиглэлээр, элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэж байгаа 12-р ангийн суралцагчидтай zoom программаар холбогдон Математикийн цахим хичээл зааж суралцагчдад давтлага, зөвлөгөө өгч ажиллаж байна. Мөн Боловсролын хүрээлэнгээс “Сурагчдын сурах үйлийн тулгамдаж буй асуудал, эцэг эхийн дэмжлэг- I” хэлэлцүүлэгт сургуулийн 81 суралцагч оролцсон.

Хүүхэд хөгжил, хамгааллын чиглэлээр доорх зөвлөмжүүдийг боловсруулан цахимаар дамжуулан эцэг эх, асран хамгаалагч, суралцагчдад хүргэсэн.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх	Ахуйн ослоос урьдчилан сэргийлэх	УОК болон ЭМЯ-ы зөвлөмж	Гэрийн нөхцөлд өөрийгөө хэрхэн хөгжүүлэх	Стрессээ тайлах, сэтгэлзүйгээ тайван байлгах чиглэлээр
16	18	15	19	22	2

Сурагчдын амралтад зориулж “Монгол өв уламжлалаа дээдэлъе” сарын аяныг зохион байгуулж, аяны хүрээнд “Би гэртээ багш” буланд 33 эцэг эхийн видео бичлэг, “Монгол наадгай болон оньсон тоглоомоор тоглож суръя” буланд 38 сурагчдын видео бичлэг, “Иргэний боловсролд” буланд 3 видео бичлэг, “АХА” буланд цахим хэлбэрээр оньсогоор АХА, “Мэдээ мэдээллийн цаг” буланд Монголын уламжлалт өв соёлыг харуулсан 8 мэдээ мэдээлэл мөн зүйр цэцэн үгсээр хэрхэн хүүхдээ хүмүүжүүлэх талаарх мэдээ, мэдээллүүдийг орууллаа.

2020-2021 оны хичээлийн жилд Сургуулийн өмнөх боловсрол, ЕБС-ийн багш нарын дунд зохион явуулах “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, “Асуудал шийдэл” сэдэвт илтгэлийн уралдааны 1-р шатны шалгаруулалтыг зохион байгууллаа.

Эрүүл мэндийн төв ньКовид-19 халдварыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээнд 328, PSR шинжилгээнд 92 иргэнийг хамруулж, нийтийн 359427 м2 талбайд халдваргүйжүүлэлт, сумын постоор нэвтэрч буй 284 автомашинд ариутгал жийж, Амбулаторийн үзлэг 1248, гэрийн эргэлт 102, жирэмсэн эхийн хяналт 46, 0-5 насны хүүхдийн хяналт 184, 0-2 насны хүүхдийн вакцинжуулалт 58, томуу, томуу төст өвчний эсрэг вакцин 70 иргэнд тус тус хийсэн. Дээд шатлалд 28 иргэнийг 13А маягтаар шилжүүлэн ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/348 тоот “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай” захирамжийг архины тусгай зөвшөөрөлтэй 13 худалдаа эрхлэгч аж нэгж байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Сумын Онцгой комиссын дарга бөгөөд Засаг даргын шийдвэрээр Баянгол сумын нутаг дэвсгэрт Гонир дугаар багт байрлалтай уул, уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Бороо гоулд” ХХК-д Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, Улс, аймаг, сумын Онцгой комиссоос гаргасан тушаал, шийдвэр тэдгээртэй холбогдон гарсан журам, заавар, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, хийж хэрэгжүүлсэн ажилд хяналт шалгалтыг зохион байгуулсан. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан мэдэгдлийг хүргүүлсэн.

2021 онд сумын Орон нутгийн орлогын жилийн төлөвлөгөө 249.6 сая төгрөг батлагдсанаас 01 дүгээр сарын байдлаар 2.9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээд байна. 2021 онд үерийн далан суваг хийх ажил 164.4 сая төгрөг, гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх ажил 98.0 сая төгрөгөөр Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10 тоот тогтоолоор батлуулсан.

Ерөө сум:

Сумын Онцгой комисс цаг үеийн байдалтай холбогдуулан 4 удаа хуралдаж холбогдох арга хэмжээг цаг тухай бүр авч хэрэгжүүлэн, холбогдох албан хаагчдад үүрэг даалгавар өгөн ажиллаж, “Ерөө сумын Онцгой комисс” Фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд мэдээ, мэдээллийг цаг алдалгүй тогтмол хүргэн 292 иргэн яаралтай бичиг гаргуулж, асуудлаа шийдвэрлүүлсэн байна.

Сумын Онцгой комиссын шийдвэрээр Улаанбаатар, Дархан бусад аймаг сумдын хүмүүст дамжин өнгөрөх хойд замын пост дээр түргэвчилсэн оношлуураар 114 хүнд шинжилгээ хийсэн.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/15 тоот захирамж, сумын Засаг даргын 2021 оны А/11 тоот “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай” захирамжийн дагуу сумын хэмжээнд 7559 м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлт, 286 айл өрхүүд нийтийн эзэмшлийн хог цэвэрлэгээг хийлээ.

Монгол Улсын хэмжээнд Коронавирусын халдвар тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан цахим сургалтыг Эрүүл мэндийн төвийн ээлжийн их эмч, сувилагч нарт зохион байгуулж, сургалтад Коронавируст халдварын үед дагаж мөрдөх тушаал шийдвэр, “Хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх, аюулгүй тайлах дараалал”, “Ариутгал халдваргүйтгэл хог хаягдлын менежмент өрөө тасалгаа, багаж хэрэглэл, түргэвчилсэн оношлуур авах аргачлал, цэр авах тээвэрлэх” зэрэг сэдвээр явууллаа. Нийт 16 ажилчид хамрагдсан.

Сурагчдын 1-р улирлын амралтаар “Багшийн мэргэжил дээшлүүлэх институт”-аас “Сонголтод сургалт”-ыг зохион байгуулж, сургалтад эрхлэгч, арга зүйч, бүлгийн 6 багш хамрагдаж байна.

“Цар тахлаас урьдчилан сэргийлэх”, “Хүүхдийг хүчирхийллийн эрсдэлд өртөхөөс сэргийлэх”, “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” зэрэг сэдвийн хүрээнд бүлгийн багш нар ангийн цахим хуудсаар дамжуулан 71 төрлийн мэдээ, мэдээлэл зөвлөгөөг хүргэн ажиллаж байна. Сурагчдын амралтад 250.000 төгрөгийн өртөг бүхий 120 ширхэг “Ном гарын авлага” бэлтгэн витамин, амны хаалт, гар ариутгагч зэргийг малчин өрхүүдийн 2-6 хүртэлх насны 58 хүүхдүүдэд хүргэх ажлыг зохион байгуулсан.

“Дэлхийн зөн” ОУБ-аас зохион байгуулсан “Би бол аав” сургалтад 30 аав онлайнаар хамрагдсан.

“Цахим орчинд соёл түгээе” аяны хүрээнд сар шинийн баярыг угтан нийт ард иргэдийн дунд “Монгол наадгай гэрэл зургийн цахим уралдаан”, “Бүжин наадъя”, “Аялгуут сайхан дуу мину” гэх зэрэг цахим уралдааныг зарлаад байна.

Монгол Улсад Шинэ үндсэн хууль батлагдсаны 29 жилийн ойг баярыг тохиолдуулан Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Гавьяат механикжуулагч С.Ганболдтой уулзалт ярилцлага хийж цахимаар иргэдэд сурталчиллаа.

Аймаг, сумын Засаг даргын “Мал тэжээвэр амьтад, хашаа, худгийн ээлжит тооллого зохион байгуулах тухай” захирамжаар 2020 оны жилийн эцсээр 92258 толгой мал тоологдож 11660 толгой буюу 14.5 хувиар нэмэгдсэн байна.

Бусад аймаг суманд өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан манай сумаас өвс тээвэрлэлт 50 гаруй иргэн 24800 боодол буюу 496 тн өвсийг Өвөрхангай, Архангай, Дорноговь, Баянхонгор, Улаанбаатар, Төв аймаг зэрэгт тээвэрлэлт хийж хяналт тавин ажиллалаа.

Жавхлант сум:

Сумын Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа, төр төсвийн байгууллагуудын дарга эрхлэгч болон албан хаагчдын шуурхай хурал 6 удаа хуралдлаа.

Аймгийн Засаг даргын хандиваар өгсөн 5000 ширхэг маскыг сумын иргэдэд тараах ажлыг зохион байгууллаа.

Улирал бүр айл өрхөөр ажилладаг “Иргэнд хүрсэн төрийн үйлчилгээ” аяныг өрнүүлж Моностой 2-р багийн 135, Бумбат 1-р багийн 102, нийт 237 өрхөд хүрч ажиллан айл бүрд 10 ширхэг амны маск, Жавхлантын мэдээ сонин, Ковид-19 халдварын зөвлөмжийг хүргэн ажиллалаа.

Ковид-19 халдварт цар тахлын хүрээнд сумын төвийн айл өрхүүдийг нэгдсэн журмаар 56 га талбайн гудамж талбайн ил задгай хог хаягдлыг цэвэрлүүлж, нийтийн эзэмшлийн талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж төвлөрсөн хогийн цэгт 26 тн хогийг зайлуулах ажил хийгдлээ.

Бумбат 1-р багийн 9 өрхөд хүнсний, 4 өрхөд түлээ нүүрсний, Моностой 2-р багийн 6 өрх нийт 19 өрхөд тусламж үзүүллээ.

Сумын Засаг даргын Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хамтран Монгол Улсын Үндсэн хууль батлагдсан түүхт 29 жилийг тохиолдуулан үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, шинээр батлагдсан хуулийг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор төр төсвийн байгууллагуудын албан хаагчдын дунд цахим тэмцээн зохион байгууллаа.

2021 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажлын санал авах хуудсыг иргэд олон нийтэд тарааж ажилласан.

Аймгийн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй”-н талаарх цахим сургалтад 5 байгууллагын ёс зүйн зөвлөлийн гишүүд, 15 төрийн албан хаагч, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах цахим сургалтад 8 албан хаагчдыг тус тус хамрууллаа.

Тухайн сард 378 хүнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж зөвлөгөө өгч ажиллалаа.Түргэвчилсэн оношлуураар нийт 104 хүн шинжилгээ хийхэд бүгд сөрөг гарсан.

Сар шинийн баярыг угтан “Малчны хотоос соёл түгээе” мэндчилгээ, “Монгол наадгай” уламжлалт уралдаан тэмцээнийг цахимаар зохион байгуулж эхлээд байна.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулж буй “Бүтээлч үйлийг дэмжих нь”, “Хүүхдийн хөгжил ба багш”, “Хүүхдийн ой тогтоолт”, “Зарраг программ ашиглах заавар”, “Цахим хэрэглэгдэхүүн, хичээл боловсруулах аргачлал, хөгжмийн хэмнэл” зэрэг 6 төрлийн сонголтод сургалтад давхардсан тоогоор нийт 12 удаа хамрагдлаа.

Ургамал, түүний гаралтай хүнсний бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ олгох ажлыг 14 иргэнд 3200 пресэлсэн өвс, 8270 ногоон тэжээл /боодол/, 82 боодол ногоон тэжээлийг /урлан/ өвөлжилт хүндэрсэн Баянхонгор, Өвөрхангай, Архангай аймагт тээвэрлэх ажлыг хийж гүйцэтгэв.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, тогтвортой экосистем ба хөдөө аж ахуйн менежментийг Монгол оронд бүрдүүлэх \STREAM\ төслийн хүрээнд сум, орон

нутагт авч хэрэгжүүлэх бодлого боловсруулах сургалтад хамрагдаж орон нутагт авч хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг хүргүүллээ.

Цар тахлын үед малчдын гар дээрх арьс ширийг борлуулах, 2020 оны арьс ширний урамшуулалд хамруулах ажлыг зохион байгууллаа.

Малчин, мал бүхий иргэдэд 44 гарал үүслийн гэрчилгээ олгосон. Үүнээс адууны мах нь 530кг, үхрийн мах 2530кг, хонь 1100кг, ямааны мах 4400кг тус тус гэрчилгээ олгож ажилласан.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай” А/15 дугаар захирамжийн хүрээнд сумын хэмжээнд төр төсвийн 5 байгууллага, 7 аж ахуйн нэгжийн нийт 6289 м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийж, нийтийн эзэмшлийн гудамж талбайн 50 га газрын 26 тн хог хаягдлыг цэвэрлэж зайлуулаад байна. Хог цэвэрлэгээний ажлыг 61 төрийн албан хаагч, 95 иргэд хийж гүйцэтгэсэн.

Зүүнбүрэн сүм:

Сумын Засаг даргын 2021-2024 оны “Өрхийг дэмжсэн- Өсөлтийн бодлого” үйл ажиллагааны хөтөлбөрийг 5 бүлгийн 132 зорилттойгоор боловсруулан төслийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барилаа.

Монгол Улсын Үндсэн хуулийг батлах үйл хэрэгт сум орон нутгаа төлөөлөн оролцсон депутат Мулцангийн Доржсүрэн агсны гэрбүлд хүндэтгэл үзүүлэн дурсгалын зүйл гардуулж, М.Доржсүрэн, Б.Элдэв-Очир агсан нарын түүх намтрыг агуулсан видеог Соёл мэдээллийн төвийн цахим хуудсанд байршуулан иргэдэд сурталчиллаа.

“Үндсэн хууль” батлагдсаны 29 жилийн ойг угтан Ерөнхий боловсролын заах аргын нэгдлээс 1-5 дугаар ангийн сурагчдын дунд хүүхдийн эрх үүргээр бяцхан ном хийх, эх орны сэдэвтэй шүлгийн уралдаан зохион байгуулж амжилттай оролцсон 8 сурагчдыг шагнаж урамшууллаа. Ахлах ангийн сурагчдын дунд “Хууль хүүхдийн нүдээр” эссэ бичлэгийн уралдаан, насанд хүрэгчдэд “Үндсэн хууль бидний амьдралд” илтгэлийн тэмцээнийг зохион байгууллаа.

Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраас зохион байгуулсан 9 удаагийн цахим сургалтад сургуулийн өмнөх боловсролын 12 багш, орон нутаг судлах танхимын ажилтан, мөн Боловсролын хүрээлэн болон багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн “Суралцахуйг дэмжих үйл ажиллагаа”, “Теле хичээл ба суралцахуй” сэдэвт онлайн сургалтад ерөнхий боловсролын сургуулийн 28 багшийг хамрууллаа.

Сурагчдын дунд зохион байгуулсан англи хэлний 21 хоногийн “Уншлагын марафон”-д дунд ангийн ангилалд сурагч М.Төгсжаргал, ахлах ангийн ангилалд А.Баатар нар “Тэргүүн байр” эзэллэлээ. Мөн Монголын сурагчдын холбооны “Шилдэг 100” хүүхдэд ерөнхий боловсролын сургуулийн 12а ангийн сурагч М.Бүжин шалгарлаа.

“Хүүхдийн суралцах үйлийг дэмжих”, “Хариуцлагатай эцэг эх байх”, “Хэрэглэсэн маскаа хэрхэн зөв хаях вэ?”, “Ковид-19 тархалтыг сэтгэлзүйн хувьд хэрхэн даван туулах аргууд”, “Гэр, сууцанд хүүхдийн аюулгүй байдлыг хангая” зэрэг цахим хичээлийг сургуулийн өмнөх боловсролын 6 бүлгийн фэйсбүүк хуудсаар дамжуулан 169 хүүхдэд хүргэлээ.

Эрүүл мэндийн төв нь амбулаториор 128 иргэнд үзлэг хийснээс өвчний учир 48, урьдчилан сэргийлэх үзлэгээр 74, диспансерийн хяналтаар 4, гэрийн идэвхтэй эргэлтээр 2 иргэнд анхан шатны үйлчилгээ үзүүлж, зөвлөгөө өгч, дуудлагаар 24 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлснээс алсын дуудлага 4 байлаа.

Ковид-19 цар тахлын үед өөрийгөө болон гэр бүлээ эрсдэлээс хамгаалах, хувийн ариун цэврийг сахих 3 үзүүлэнг амбулаторийн үүдэнд байршуулсан бөгөөд “Зүүнбүрэн Эрүүл мэндийн төв” фэйсбүүк хуудсанд шаардлагатай мэдээллүүдийг байршуулан иргэдэд нээлттэй сурталчлан ажиллаж байна.

Орон нутаг судлах танхимын үүсэл хөгжил, соёлын биет бус өв тээгч, өвлөн уламжлагчид болон түүх соёлын үл хөдлөх биет өвийн тухай видео танилцуулга хийж иргэдэд хүргэлээ.

Аймгийн нэгдсэн музейгээс зохион байгуулсан “Миний мэдэх музей” цахим уралдаанд Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 10А ангийн сурагч М.Намуун “Тэргүүн байранд шалгарлаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай” А/15 захирамжийн хүрээнд 17 объектын 6887 м2 талбайг халдваргүйжүүллээ.

Мандал сум:

“Хүнээ дээдлэн, үйлдвэрлэлтийг дэмжиж, Хамтын хүчээр сумаа хөгжүүлье” гэсэн зорилго бүхий 4 бүлэг, 15 дэд бүлэг 160 арга хэмжээ бүхий энэхүү хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2020 оны орон нутгийн сонгуульд оролцсон Монгол Ардын нам, Ардчилсан нам, бие даагчийн мөрийн хөтөлбөр, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар болон сумын ААНБ, иргэд сонгогчдын саналуудыг судлан иргэдийн амьдрал, сум орон нутгийн онцлогуудыг харгалзан нэн тэргүүнд тулгамдаж байгаа асуудлыг тусган боловсруулж, хэлэлцүүлж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11 тогтоолоор батлууллаа. Мөн 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлууллаа.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд анх удаа, шинээр сонгогдсон төлөөлөгч нарт Нийтийн албан дахь хориглолт, хязгаарлалтын талаар сургалт зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай” А/15 тоот захирамжийн хэрэгжилтийн ханган ариутгал халдваргүйтгэлийг 8 багийн 39 албан хаагч хүнсний худалдаа үйлчилгээний 114 ААНБ-ын 8275 м2, нийтийн орон сууцны 51 байрны 10801 м2, хоол үйлдвэрлэл, бусад худалдаа үйлчилгээний 117 ААНБ-ын 33912 м2, төр төсвийн 32 ААНБ-ын 53564 м2, 4 дотуур байрны 4918 м2 нийт 318 объектын 111,470 м2 талбайд хийлээ.

Нийтийн номын сангаас “Номын сурталчилгаа”, “Богино өгүүллэг”, “Үлгэр” “Цахим ном”, “Өв соёлын мэдээлэл”, “Хүчирхийлэлд өртөх эрсдэлээс сэргийлэх зөвлөмж”, “Коронавирусын зөвлөмж”, “Танин мэдэхүйн мэдээлэл” зэрэг нийт 106 мэдээллийг цахимаар 7138 иргэнд хүргэсэн.

“Хөгжлийн бэрхшээлтэй” 93 хүүхдэд “Шинэ жил”-ийн гарын бэлэг гардууллаа. Мөн Сумын иргэдийн төлөөлөгч, Хүүхдийн элч Ч.Машбат бүтэн өнчин 17 хүүхдэд шинэ жилийн бэлэг, нэг машин /портер/ түлээний мод олголоо.

Сумын амьжиргаа дэмжих зөвлөл тайлант сард 2 удаа хуралдаж байнгын асаргаа шаардлагатай ахмад настан 7, сунгалт 10, хөгжлийн бэрхшээлтэй иргэн шинээр 3, сунгалт 5, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сунгалт 12 нийт 37 иргэний өргөдлийг шийдвэрлэв.

Халамжийн нэгдсэн системд нийт 3948 иргэний материалыг бүртгүүлж Ehalamj.mn системд хөрвүүлэн баталгаажуулж, дансгүй иргэдийг дансжуулах ажлыг зохион байгууллаа.

Ахмад настнуудад сар шинийн хүндэтгэл үзүүлэх ажлын хүрээнд харьяалалгүй 510, насны хишигт хамрагдах 993 өндөр настан, алдарт эхийн I, II одонтой 1500 иргэнийг төрийн банкттай хамтран нэрийн дансыг холбов.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг нийт 197 өрхийн 1177 гишүүнд 14.0 сая төгрөг олгосон байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/335 тоот, сумын Засаг даргын 2020 оны А/247 тоот “Мал тэжээвэр амьтад, хашаа худгийн ээлжит тооллого явуулах, хөрөнгө гаргах тухай” захирамжийн дагуу 2020 оны жилийн эцсийн мал тэжээвэр амьтны тооллогыг зохион байгуулж, нийт 127089 толгой мал тоологдсон бөгөөд адуу 9.8 хувь, үхэр 14.4 хувь, хонь 15.6 хувь, ямаа 6.9 хувиар өссөн, тэмээ 50 хувиар буурсан байна.

Сумын мал эмнэлгийн үржлийн нэгжүүд 34 төрлийн эмийн татан авалт хийж малчид, мал бүхий иргэдэд үйлчилж байна. Шимэгч өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 7365 толгой мал амьтныг хамрууллаа.

Мал эмнэлгийн цахим системээр дамжуулан 715 өрхийн 51 адуу, 15 үхэр, 15 хонь, 1575 кг адууны мах, 4449кг үхэр, хонины мах, 5163 кг ямааны мах, 339722 литрсүүнд гарал үүслийн гэрчилгээ олголоо. Сумын хүнсний бүтээгдэхүүний татан авалт хийх зорилгоор Улаанбаатар хот руу зорчих 27 тээврийн хэрэгсэлд QR код олголоо.

Хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичгийг 8 аж ахуй нэгж байгууллагад 1905м³, түлээний эрхийн бичгийг 150 иргэнд 1351 м³, гарал үүслийн гэрчилгээг хэрэглээ 317м³, түлээ 109 м³ олголоо. 20-н өрхөд хөнгөлөлттэй үнээр түлээ олголоо.

4 аж ахуй нэгж байгууллага 66 га талбайд мод бэлтгэлийн талбай тусгаарлалтын ажил хийлээ. Хууль бус мод бэлтгэл, ашигт малтмал олборлолт, ан агнуур, хуш модны үр боргоцойг түүж бэлтгэх арга хэмжээнд хяналт төлөвлөгөөт шалгалтыг 7 хоног бүрийн пүрэв гаригт тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

Хуш модны самар бэлтгэх үйл ажиллагаанд хяналт тавих Барчулуутын хяналтын цэгийг “Хонин нуга”-т шилжүүлэн байршууллаа. Хуш модны самар бэлтгэх гэрээний хугацаа болон самар бэлтгэлийн эрхийн бичгээр олгосон хэмжээ дууссан 20 ААНБ-д “Үйл ажиллагааг зогсоох тухай” улсын ахлах байцаагчийн актыг хүргүүлж үйл ажиллагааг түр зогсоов.

Хуш модны самар бэлтгэхээр зөвшөөрөл авсан 162 хэрэгслийн жолоочтой хариуцлагын гэрээ байгуулж, 129 иргэнд ойд зорчих тасалбар олгож 1701000 төгрөгийн хураан авч төрийн санд төвлөрүүлээ.

Орхон сүм:

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг удирдлага болгон сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 4 бүлгийн 12 дэд бүлэгтэй, 97 ажил арга хэмжээг хэрэгжүүлэхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж 2021 оны 13 тоот тогтоолоор батлууллаа.

Сумын Засаг даргын 2021 оны А/01 тоот “Ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай” захирамжийн хүрээнд Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажиллах хуваарийн батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/15 “Бүх нийтийн ариутгал, халдваргүйжүүлэлтийг ажлыг эрчимжүүлэх” захирамжийн хүрээнд 25 ААН, байгууллагын 4751 м² талбайд халдваргүйжүүлэлт хийгдсэн.

Сумын ИТХ-ын 2021 оны 14 тоот тогтоолоор Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлууллаа.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд зорилтод бүлгийн 14 өрх иргэнд 450000 төгрөгийн тусламжийг үзүүлсэн.

“Дэлхийн зөн Монгол” ОУБ-аас цахимаар зохион байгуулсан “Төсөл хэрхэн бичих бэ” сургалтад 18 иргэн, “Хүүхдийн хүмүүжилд аавуудын оролцоо”, “Зөв үлгэрлэл”, “Уур ба ухаан, уучлал ба тэвчээр” сургалтад 18 иргэн, “Бизнес санаа”, танхимын сургалтад 30 өрхийг хамруулж зах зээлийн түргэвчилсэн судалгааг авч ажиллалаа.

2020 онд мал тооллогоор сумын хэмжээнд 428 өрхийн 6165 адуу, 13061 үхэр, 44124 хонь, 45284 ямаа нийт 108634 мал тоолуулсан бөгөөд “Бүрэн-Орхон” ХХК мал эмнэлэг 51742 толгой мал, “Эгдэм” БГБХН мал эмнэлэг 56912 толгой малд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхээр өрхийн товчоог гаргаж батлууллаа.

Орон нутгийн байгууллагуудын төсвийн санхүүжилтийн зарцуулалтын гүйлгээг батлагдсан төсвийн дагуу анхан шатны баримтыг үндэслэн 20611407 төгрөгийн гүйлгээ хийлээ.

Орхонтуул сүм:

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр коронавируст /Ковид-19/-ын халдвараас урьдчилан сэргийлэх, халдварын эрсдэлийг бууруулах зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд төрийн албаны тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг найдвартай хангаж, дэмжлэг үзүүлэх төрийн байгууллагаас авч хэрэгжүүлэх зөвлөмжийн дагуу Улсын Онцгой комисс, дээд шатны мэргэжлийн байгууллагаас гаргасан халдвар хамгааллын дэглэм, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай шийдвэр, зөвлөмжүүдийг тухай бүрд хэрэгжүүлэн ажиллаж, тогтоосон хэмжээг чанд мөрдөж, холбогдох мэдээ тайланг тухай бүрд өгч ажиллаж байна.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлууллаа.

Сумын Онцгой комиссоос сумын хэмжээнд “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийг эрчимжүүлэх тухай” сумын Засаг даргын 2021 оны А/04 тоот захирамжийн дагуу сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах, бүх нийтийн халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулж сум тосгоны хэмжээнд 47 байгууллагын 29374м² талбайд хийлээ.

Сумын Онцгой комиссоос суманд ирж байгаа болон гарч буй иргэдийн PCR-шинжилгээний хариу, бичиг баримтыг хянан шалгах “Шалган нэвтрүүлэх баг”-ийг тогтмол ажиллуулж байна. Сумын хэмжээнд өнөөдрийн байдлаар 23 өрхийн 45 иргэн, түүний хамаарал бүхий 46 иргэн нийт 44 иргэнийг 14 хоногийн гэрийн тусгаарлалтад авч, хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/07 тоот захирамж, сумын Засаг даргын 2021 оны А/03 тоот захирамжийн хүрээнд сумын Засаг даргын Тамгын газраас ардчилсан шинэ үндсэн хууль батлагдсаны 29 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Монгол Улсын Үндсэн хууль, түүхийн товчоо” сэдвээр гарын авлага бэлтгэн цахим орчинд байршууллаа.

Аймгийн Биеийн тамир, спортын газраас зохион байгуулж буй “Дасгалаар дархлаагаа дэмжицгээ” цахим арга хэмжээний хүрээнд сумын төр, төсвийн байгууллагуудыг хамруулан өдөр бүр 11:00 цагт сумын соёлын төвд 30 минутын ажлын байрны дасгалыг хийж хэвшүүлээд байна.

“Төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа дэд хөтөлбөр”-ийн хүрээнд сэтгэлийн дэм аяныг сумын төр, төсвийн байгууллагуудад өрнүүлэн 7 байгууллагын 7 ажилтанд 5862,0 мянган төгрөгийг өгсөн.

01 дүгээр сард 204 цахим гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж, амьдаар адуу 19 толгой, үхэр 20, хонь 253, ямаа 223, нийт 515 мал амьтан хүнсний зориулалтаар бичиж олгоод байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл худалдаа, хүнсний зориулалтаар адууны мах 6778 кг, үхрийн мах 14140 кг, хонины мах 6550 кг, ямааны мах 14639 кг нийт 42107 кг маханд цахим гэрчилгээ бичигдсэн.

Сайхан сүм:

Аймгийн Засаг даргын 2021 оны “Цэргийн бүртгэл зохион байгуулах тухай” А/04 дүгээр захирамжийн хүрээнд Сайхан суманд бүртгэлтэй 18-50 насны эрэгтэйчүүд, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд, бэлтгэл болон төрийн тусгай албанд ажиллаж буй ахлагч офицеруудын нэгдсэн бүртгэл, дүн мэдээг гарган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” А/07 дугаар захирамжийн хүрээнд 12 төрлийн зураг постор, 4 төрлийн бичлэг 4 төрлийн мэдээллийг 32 бүлгэмийн 5869 иргэнд сурталчлан ажиллалаа. Мөн байгууллага тус бүр Google meet болон Zoom программаар албан хаагчдынхаа дунд сургалт зохион байгуулж, 14 байгууллагын 312 ажилтан, албан хаагчид хамрагдсан.

- Сайхан 1-р сургууль “Сурагчдын дунд асуулт хариултын тэмцээн”
- Сайхан 2-р сургууль сурагчдын дунд “Тусгаар тогтнолын үнэ цэнэ” гар зургийн уралдаан
- “Эрх чөлөө, тусгаар тогтнолын үнэ цэнэ” сэдэвт цахим эссэ бичлэгийн уралдаан
- Сурагчдын дунд “Үндсэн хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтийн ач холбогдол” сэдэвтэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тухайн хэлэлцүүлэгт цахимаар 1-12 ангийн 25 сурагчид, 8 эцэг эх хамрагдлаа.

Номгон тосгонд архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй 4 аж ахуйн нэгжид хяналт шалгалтыг хийж 1731 ширхэг нийт 893 л согтууруулах ундаа лацадсан байна.

Засгийн газрын хэрэг эрхлэх газраас явуулсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах” сургалтад Засаг даргын Тамгын газрын 13 албан хаагч хамрагдав.

Байгаль орчны хяналтын чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2 удаа, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 3 удаа тус тус зохион байгуулж, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй газрын хэвлийг ашигласан 1 иргэнд, зөвшөөрөлгүй ан амьтан агнасан 2 иргэнд тус тус Монгол Улсын зөрчлийн тухай хуулиар 450.000 төгрөгийн торгууль, шийтгэлийн арга хэмжээ авч ажилласан.

Коронавирусаас урьдчилан сэргийлэх зорилгоор сумын өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нийт 22 иргэний 45 м3 түлээний мод модон материалд гарал үүслийн гэрчилгээний бичилт хийж, 23 иргэнд мод бэлтгэх эрхийн бичиг бичиж өгсөн.

Сумын малын тоонд адуу 5369, үхэр 13437, хонь 54356, ямаа 46842 нийт 120004 тоологдсон. Өмнөх онтой харьцуулахад адуу 224, үхэр 1098, хонь 7542, ямаа 6100 нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Сумын хэмжээнд нийт 120.004 толгой малтай, малчин, мал бүхий 577 өрхтэй байна. Тус сард 93 буюу адуу 17, үхэр 15, хонь 82, ямаа 70 гарал үүслийн баталгаажуулалтын гэрчилгээг цахимаар олгосон байна. Мах махан бүтээгдэхүүнд адууны мах 1645 кг, үхрийн мах 5997 кг, хонины мах 3623 кг хонины гулууз мах 227 ширхэг, ямааны мах 1751кг, ямааны гулууз мах 1560 ширхэг, сүү

сүүн бүтээгдэхүүнд сүү 2771 л, ааруул 30кг, аарц 35 кг, өрөм 6 кг, тараг 40 кг худалдаанд болон хүнсэнд гарсан байна.

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хорио цээрийн хугацаанд аж ахуйн нэгж байгууллагуудаар ариутгал халдваргүйжүүлэлтийг Онцгой байдлын албан хаагчидтай хамтран нийт 66 байгууллагын 80866 м2 талбайд ариутгал хийж, хяналт тавин ажиллалаа.

Сайхан суманд үйл ажиллагаа явуулж байгаа 1, 2-р багт байрлах хүнсний дэлгүүр, мухлаг, хоол үйлдвэрлэл үйлчилгээний 50 гаруй ААНБ-аар “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар”-т тавих шаардлага MNS 4946:2019, “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ” MNS5021-1:2019 стандартуудын дагуу гарын авлага, зөвлөмж, санамж зэргийг боловсруулан хэвлэн тараалаа

Хөл хорионы дэглэмтэй байгаа энэ цаг үед хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, дархлааг дэмжих, гэрбүлийнэвнэгдлийгбэхжүүлэх, үр хүүхдээ зөв сайхан хүмүүжүүлж, өөрсдийн бүжгийн эвсэл, авьяас ур чадварыг нээн дэлгэрүүлэх, мөн цахим орчинд эерэг зөв зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор “Гэрээс гэрэлтэх авьяас”, “Бүтээлч гэр бүл”цахим уралдааныг тус тус зохион байгуулан ажиллаж байна.

Сант сум:

Аймгийн Засаг даргын 2021 оны А/04 дүгээр захирамж, сумын Засаг даргын 2021 оны А/01 “Цэргийн бүртгэл зохион байгуулах тухай” захирамжийг хэрэгжүүлэн цэргийн тоо бүртгэлийг зохион байгуулж, хамрагдалт 89 хувьтай явагдсан байна.

“Бүх нийтийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай” аймгийн Засаг даргын 2021 оны А/15 дугаар захирамжийн дагуу сумын хэмжээнд нийтийн эзэмшлийн зам талбай, 11 аж ахуйн нэгж, байгууллагын 5160 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийлээ.

“Малын тоо толгойн татварын хууль” батлагдсантай холбоотой малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох бэлтгэл ажлын хүрээнд сумын МАА-н өнөөгийн байдал, бэлчээрийн хүрэлцээ хангамжийн судалгааг гаргахад сумын хэмжээнд мал сүргийн тоо 63980 тоо толгойгоор ихэссэн, бэлчээрийн даац 3 дахин хэтэрсэн, бэлчээрийн дундаж ургац 0,9 цн/га байна.

2021 онд тариалах талбай, нөөцөлсөн үр болон дутагдах үрийн судалгааг гаргаж 4247 га талбайд үр тариа, 260 га талбайд төмс, 130 га талбайд хүнсний ногоо тариалах дүнтэй байна. Сумын хэмжээнд нөөцөлсөн үр 300 тн, дутагдах үр 492,3 тн байна.

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны А/105 дугаар тушаал “Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам”-ын дагуу сумаас тээвэрлэгдэн гарсан 2 иргэний 12 тн төмс хүнсний ногоо, 1 аж ахуйн нэгж, 4 иргэний 320 тн хадланд гарал үүслийн гэрчилгээ олголоо.

“Идэш” арга хэмжээний хүрээнд иргэдээс ирсэн захиалгыг нэгтгэн, хүргэх ажлыг зохион байгуулж сумаас Улаанбаатар хотруу 3 удаагийн тээвэрлэлтээр 23 иргэнд 2,74 тн махыг хүргээд байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” А/07 дугаар захирамжийн хүрээнд “Үндсэн хуулийн тухай ойлголт, түүхэн замнал” сэдэвт сургалт мэдээллийн ажлыг цахимаар зохион байгуулж, “Монгол Улсын Үндсэн хууль” сэдэвт гарын авлага бэлтгэж иргэдэд хүргэсэн. Сумын орон нутаг судлах танхимаас сум орон нутагт ажиллаж амьдарч байсан АИХ-ын3 депутатын намтар түүхийг өгүүлсэн мэдээллийг “Ивэн голын хүүхдүүд” цахим группт байршуулж сурталчиллаа.

Ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгах, журмын хүрээнд хянан шийдвэрлэх талаар арга зүйн зөвлөмж болон зөвлөмжийг хэрэгжүүлэх тухай сумын Засаг даргын албан тоотыг төсвийн 5 байгууллагад хүргүүллээ. Зөвлөмжийн дагуу сургууль, цэцэрлэгийн байгууллага нэмэлт өөрчлөлтийг байгууллагын дотоод журамд тусгасан байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, улсын Онцгой комиссоос гаргасан зөвлөмжийн дагуу аймгийн Засаг даргын 2020 оны А/348 тоот захирамжаар батлагдсан халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, дасгал хөдөлгөөнөөр дархлаагаа дэмжих ажлын хүрээнд “Дасгал хийж- Дархлаагаа дэмжье” challenge-г зарлаад байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөлөөс Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны Зөвлөл, Орон нутгийн тогтвортой хөгжлийн институттэй хамтран “Төрийн байгууллага, нэгжийн болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах нь”, “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт 2 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 42 албан хаагч хамрагдлаа.

“Дэлхийн Зөн Монгол” ОУБ, “Сэлэнгэ нэгдсэн хөтөлбөр”, “Хөгжлийн шийдэл” ОУБ-ын BEST төсөлтэй хамтран “Төсөл хэрхэн бичих вэ?”, “Сайн аав” зэрэг цахим сургалт зохион байгуулж 47 иргэнийг хамрууллаа.

Сумын Эрүүл мэндийн төвөөс Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, шуурхай штабын бүрэлдэхүүнд “Ковид -19 халдварын тухай ойлголт, илрэх шинж тэмдэг”, “Ажлын байранд Ковид-19 халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, ажилтны эрүүл мэндийг хамгаалах зөвлөмж”, “Ариутгал халдваргүйжүүлэлт” сэдвээр сургалт мэдээллийн ажлыг зохион байгуулж 24 хүн хамрагдлаа.

Сүхбаатар сум:

Аймгийн Засаг даргын 2021 оны А/04 дүгээр захирамж, сумын Засаг даргын 2021 оны Б/03 “Цэргийн бүртгэл зохион байгуулах тухай” захирамжийг хэрэгжүүлэн цэргийн тоо бүртгэлийг зохион байгуулж, байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” А/07 дугаар захирамжийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад болон иргэдэд сумын цахим хаягаар Монгол Улсын Үндсэн хуулийг сурталчлан Монгол Улсын үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт, нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын талаар танилцуулж сургалт зохион байгууллаа.

Засгийн газрын 2020 оны 100 дугаар тушаалын хэрэгжилтийг ханганаймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах тухай” цахим сургалтад төрийн захиргааны 12, харьяа байгууллагын үйлчилгээний удирдах 15 албан хаагчдыг тус тус хамрууллаа.

Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг байгуулан боловсруулан Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүллээ.

Коронавируст халдвар /Ковид-19/ өвчнөөс урьдчилан сэргийлэх бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын үед сумын Засаг даргын “Гамшгаас хамгаалах бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, худалдаа үйлчилгээ, нийтийн хоол, үйлдвэр үйлчилгээний газрыг нээж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 01 дүгээр сарын 02- 18-ны өдөр хүртэл дугаарын хязгаарлалтаар явуулах, тус сумаас орох гарах тээврийн

хэрэгслийн хөдөлгөөний хянах хяналтын Шаамар 6 постод хамтарсан багийг томилгоожуулан ажиллуулж байна. Мөн сумын хэмжээнд зорчих тээврийн хэрэгслийн хөдөлгөөний дугаарын хязгаарлалтыг 18-ны өдрөөс эхлэн хэвийн горимд шилжүүлээд байна.

“Сүхбаатар сум Сэлэнгэ аймаг” цахим хаягт зурагт хуудас 25, коронавируст /Ковид-19/ халдварт өвчний цаг үеийн нөхцөл байдлын хэвлэлийн бага хурлыг 26, видео контент 58, мэдээ, мэдээлэл /захирамж, албан тоот, Сүхбаатар суманд хийгдэж буй ажлууд болон хийгдсэн ажлууд/ 215 байршуулж иргэдэд хүргэлээ.

Сүхбаатар суманд 1626 тээврийн хэрэгслээр 3411 зорчигч орж ирснээс 165 тээврийн хэрэгслээр 307 иргэн Улаанбаатар хотоос орж ирсэн байна. Сүхбаатар сумаас 1324 тээврийн хэрэгслээр 2950 зорчигч гарснаас 124 тээврийн хэрэгслээр 303 иргэн Улаанбаатар хот руу зорчсон байна. Улаанбаатар хотоос ирсэн иргэдэд GPS application суулган багийн Засаг дарга нар хэсгийн байцаагч нартай хамтран хяналт тавьж мэдээг авч АОК руу тогтмол хүргүүлэн ажиллаж байна.

Гэрийн тусгаарлалтад 177 өрхийн 404 иргэнд хяналт тавин ажиллаж байна. ЭМТ-д 87 иргэн хэвтэн эмчлүүлж байна.

Асран хамгаалагчаар авахаар хүсэлт гаргасан 1, үрчлэлтийн 1 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажиллалаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 08 тоот тогтоол, Түшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 тоот “2021 онд ойгоос бэлтгэх үйлдвэрлэлийн болон хэрэглээний мод, түлээний хуваарь батлах тухай” тогтоолын хүрээнд сумын иргэдийн ахуйн хэрэглээнд түлээний зориулалтаар 1000 м3 нарс модыг бэлтгүүлэх гэрээ байгуулж, Түшиг сумын Хар горхиос 400 м3 түлшний модыг 100 иргэнд олгоод байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/15 тоот захирамжийн хүрээнд бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулж, хяналт тавин ажиллаж хүнсний чиглэлийн 44 объектын 5200 м2 талбай, хүнсний бус нийтийн эзэмшлийн 7 объектын 5100 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн байна.

Сумын Засаг даргын А/243 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын хэрэгжилтийг хангуулах ээлжит хяналт шалгалтыг хүнс болон барааны дэлгүүр, нийтийн хоол, үсчин нийт 50 газарт хийж, худалдаа, үйлчилгээний газруудад QR кодоор үйлчлүүлэгчдээ нэвтрүүлэх зөвлөмж өгч ажиллалаа.

Төсвийн 16 байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг шалган хүлээж авч, төрийн сангийн нэгдсэн системд өр авлагын мэдээг шивж баталгаажууллаа.

- Өглөгийн хэмжээ 18,332,190²⁰ байснаас 0 төгрөгийн үлдэгдэл буюу 100 хувийн бууралттай гарсан байна.
- Авлагын хэмжээ 26,895,466⁷⁹ байснаас 15,257,028³¹ төгрөгийн үлдэгдэл буюу 56,72 хувийн бууралттай гарсан байна.

Түшиг сум:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 21 дүгээр тогтоолоор Түшиг сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталлаа.

Коронавируст халдвар “Ковид-19” өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор шуурхай штабыг 24 цагаар ажиллуулж, сумаас гарах хөдөлгөөн болон аймаг орон нутгаас ирэх хөдөлгөөнд хяналт тавьж, хүндэтгэн үзэх шалтгаантай иргэдийг холбогдох бичиг баримтыг шалган, халдвар хамгааллын дэглэмийг сайтар сахиулан зөвшөөрөл олгож байна. Мөн халдварын голомтоос ирж байгаа иргэдийг 14 хоногийн хөл хорионд

оруулан түүнд хяналт тавин ажиллаж, өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотоос ирсэн 7 өрхийн 25 иргэд гэрийн тусгаарлалтад байна.

Үндсэн хууль батлагдсан өдрийг тохиолдуулан “Хүний эрх, эрх чөлөө” сэдэвт гар зургийн уралдааныг цахимаар зохион байгуулж, “Танил хүн” цахим ярилцлагыг явуулж, цахимаар нийтийн хүртээл болголоо. “Танил хүн” ярилцлагад Түшиг сумын анхны Засаг дарга Ш.Баясгалан оролцлоо.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу Засаг даргын орлогчоор томилогдохоор нэр дэвшсэн Ц.Мөнхсайханы холбогдох материалыг хүргүүлж, хянуулан Засаг даргын орлогчийн албан тушаалд томиллоо.

Аймгийн “Аварга тариаланч”, “Улс, аймгийн аварга малчин”-аар шагнуулахаар холбогдох материалыг бүрдүүлж Хүнс, Хөдөө аж ахуйн газар болон дээд шатны байгууллагад хүргүүлээ.

Малын тэжээл дутагдалтай байгаа өрхийн судалгааг гаргаж, нийт 43 өрхөд 13 тн тэжээлийн будааг “Гацуурт” ХХК-иас малчин, мал бүхий өрхүүдэд тараан, 50 кг тэжээлийн будааг хөнгөлөлттэй буюу 28,500 төгрөгөөр борлуулалт хийлээ.

2021 оны мод бэлтгэх хуваарийн дагуу “Шинэбадрах” ХХК, Хар горхид 1 талбай, Улаанбаатар төмөр замын мод боловсруулах үйлдвэр “Ар шүрэн”-д 3 талбайд мод бэлтгэх талбайг тусгаарлалт хийж, үйлдвэрлэлийн огтлолоор 644,39 м3 шинэс мод бэлтгэх эхлэлийн акт үлдэж мод бэлтгэх эрхийн бичиг гүйцэтгэсэн, “Мойлт нуга” ХХК-ий 2020 онд бэлтгэсэн модны үлдэгдлийг газар дээр нь үзэж танилцан хэмжилт хийж тээвэрлүүлэх ажлыг хийлгүүлж, хяналт тавин ажилласан. Зүүнбүрэн сум 500 м3 нарс түлээ, Сүхбаатар сум 1500 м3 нарс түлээ бэлтгэх гэрээ байгуулан хяналт ажиллаж байна.

Цахим орчинд сурагчдын заавал унших зохиолууд буюу “Нууцыг задруулсан захиа”, “Үр могой”, сургамжит өгүүллэг, цахим үлгэр зэрэг нийт 20 эхийг, мөн хүүхэд багачуудыг танин мэдэхүйн болон оюуны хэрэгцээнд зориулж цахим группд ёс заншил, монголын уламжлалт наадгай, үндэсний хөгжим суралцах анхан шатны зөвлөмжүүдийг байршуулсан.

Цэцэрлэгийн багш нар багшийн мэргэжил дээшлүүлэх цахим сургалтад эрхлэгч 5, арга зүйч 3 удаа, бусад багш нар 1 удаа хамрагдсан. Цахим орчин ашиглан хүүхдийн хийж буй дасгал даалгаврыг хянан шалгах, заавар зөвлөгөө өгөх гэх зэргээр ажиллаж байна. “Бэлтгэл бүлгийн хүүхдэд зориулсан даалгаврын ном” багш нар хамтран бэлтгэж хүүхэд тус бүрд хүргүүлэн ажиллалаа.

Малчин өрхийн 93 сурагчдад судлагдахууны багц бэлтгэн, хичээлийн хоцрогдлыг арилгах үйл ажиллагаанд сургуулийн захиргаанаас анги удирдсан багш болон мэргэжлийн багш нарын судлагдахуун бүрээр бэлтгэсэн гарын авлагыг хүргэх ажлыг хийсэн.

Хушаат сум:

Сумын Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл бэлтгэх ажлын хэсгийг томилон төслийг бэлтгэн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн аймгийн Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлогын хэлтсийн дүгнэлт, саналыг аваад байна. Мөн МУЗГ-ын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрүүд, үндсэн чиглэлүүдийг татан авч байгууллага, албан тушаалтнуудыг бодлогын баримт бичгээр хангалаа. Төрийн байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлан гаргах талаар цахим сургалтад байгууллагын 5 удирдах, 12 төрийн албан хаагч оролцож мэдээлэл авлаа.

Орхон голын гүүрний постоор нийт 132 тээврийн хэрэгсэл 243 хүн орж, 137 тээврийн хэрэгсэл, 267 хүн гараад байна. Өссөн дүнгээр 19241 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийлээ.

Сумын иргэд сайн үйлсийн аянд нэгдэн сумын Онцгой комиссын үйл ажиллагаа, хяналтын цэгийн хүнсэнд зориулан 100.000 төгрөг, 2 хонь, 25 кг аарц, 20 л сүү хандивлалаа. Сумын байгууллага, иргэдээс 2 өрхөд тус бүр 1 хонь, 6 өрхөд нийт 60 шуудай хөнгөлөлттэй нүүрс, 12 өрхөд тусламжийн хувцас олгосон.

Сумын Засаг даргын 2020 оны А/135 дугаар захирамжаар Хүн ам, мал, хашаа, худгийн ээлжит тооллогыг зохион байгуулж, 2019 оны жилийн эцсийн мал тооллого 88405 байсан бол 2020 жилийн эцсээр 102876 толгой мал болж, 14471 толгой малаар өссөн байна.

Хүн ам 2019 онд 2065 байсан бол 2020 онд 2113 болж 48 хүнээр өссөн үзүүлэлттэй байна. Өрхийн тоо 2019 онд 570 байсан бол 2020 онд 577 болж 7 өрхөөр нэмэгдсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр энэ сард 17 иргэнийг ажлын байранд зуучилсан байна.

Халамжийн чиглэлээр 220 иргэнд 23,836,970 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр тэтгэмж олгосон байна.

“Улсын аварга тариаланч хамт олон”-д 3 аж ахуй нэгж, “Улсын аварга тариаланч”-д 2 тариаланч, “Аймгийн аварга тариаланч хамт олон”-д 1 аж ахуй нэгж, “Аймгийн аварга тариаланч”-д 2 тариаланч, “Аймгийн аварга ногоочин”-д 1 хүнийг тус тус нэр дэвшүүлж бүрдүүлэх материалын хамт аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэн ажиллалаа.

Хүдэр сум:

Сумын Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Малын тоо толгойн татварын хувь хэмжээг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлууллаа. Мөн Сум хөгжүүлэх сангийн тогтоолын биелэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, 2021 оны төсөв, чиглэл, хяналтын комисс, зээл олгох комисс, зээлийн дээд хэмжээг тогтоон батлуулсан.

Сумын Онцгой комиссын хуралдаан 1 удаа хуралдаж холбогдох шийдвэрүүдийг гарган шийдвэрүүдийг гарган хэрэгжилтийг ханган ажиллах талаар үүрэг өглөө. Суманд Улаанбаатар хотоос 41 тээврийн хэрэгсэл, 75 иргэн, бусад аймаг, сумаас 338 тээврийн хэрэгсэл, 742 иргэн ирж, Улаанбаатар хотруу 44 тээврийн хэрэгсэл, 85 иргэн, бусад аймаг сумруу 314 тээврийн хэрэгсэл, 684 иргэн явж, гэрийн тусгаарлалтад 12 өрхийн 49 иргэн байна.

Ариутгал халдваргүйжилтийг 139 цэгт 29567м2 талбайд хийсэн байна. Мөн зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын Засаг даргын 2021 оны А/08 захирамжийн дагуу сумын төвийн 0.8 метр бетонон замын цас цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, нийт 141 ажилтан албан хаагч, иргэд оролцсон байна.

2021 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор хэрэглээний 4400 м3, түлээний 9405 м3 нийт 13.805 м3 мод хуваарилагдсан.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2021 оны 18/02 тоот “Хяналт шалгалт хийх тухай” байнгын удирдамж, сумын Засаг даргын 2020 оны А/137 тоот “Ойгоос хэрэглээний болон түлээний мод бэлтгэлийн ажлыг зохион тухай” захирамжийн дагуу хяналт шалгалтыг 3 удаа хийж, шалгалтад 5 иргэн, 21 аж ахуй нэгж хамрагдсан. Хяналт шалгалтын явцад зохих зөвшөөрөлгүй эзэн холбогдогч нь тодорхойгүй бэлтгэгдсэн 10 м3 нарсан гуалинг төвлөрүүлэн ажилласан.

2020 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1 тэрбум 200 сая төгрөгийн өртөгтэй 672 м2 талбайтай 2 давхар Эрүүл мэндийн төвийн барилга ашиглалтад орж, сумын хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг стандартын дагуу үзүүлж давхардсан тоогоор 635 иргэнд үйлчилсэн байна. Коронавирус илрүүлэх түргэвчилсэн шинжилгээ 492 хүнд хийж, товлонд вакцинд давхардсан тоогоор 94 иргэн, тархвар судлалын заалтаар галзуугийн эсрэг вакцинд 1 иргэн хамрагдсан байна.

Хүдэр сум байгуулагдсаны 50 жилийн ойг угтаж Соёлын төв болон орон нутаг судлах танхимын зүгээс түүхэн он жилүүдийг “Дурсамж сэргээсэн сайхан зургийг” цуглуулах ажил, Бүжгийн багш цувралаар иргэд болон хүүхэд багачуудад 1-2 минутын дасгалуудыг цахим сүлжээнд байршуулж ажилласан.

“Дэлхийн зөн Монгол” ОУБ-ын “Сэлэнгэ нэгдсэн хөтөлбөр”-тэй хамтран “Би бол аав” аавуудад зориулсан сургалтыг Хан голомт сургалтын төвөөс зохион байгуулж 22 аавыг хамруулсан.

Сумын ойн мэргэжлийн аж ахуйн нэгж, байгууллагууд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд зорилтот 10 өрхөд түлшний модны дэмжлэг үзүүлсэн.

Цагааннуур сум:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, сумын 2021 оны Хөгжлийн хөтөлбөр хэлэлцэн баталлаа.

Сумын Шуурхай штабт Засаг даргын Тамгын газрын албан хаагчид 24 цагийн ээлжээр ажиллан, цаг үеийн мэдээллийг иргэдэд хүргэн, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

“Монгол Улсад шинэ Үндсэн хууль батлагдсаны 29 жилийн түүхт өдөр”-ийг тохиолдуулан Үндсэн хуулийн ач холбогдол, түүхэн замнал нөхцөл байдлуудын талаар иргэдэд мэдээлж, Үндсэн хууль батлах депутатаар сум орноосоо сонгогдон оролцсон Монгол Улсын Гавьяат механикжуулагч Нацагийн Дэлгэрмөрөнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зүгээс хүндэтгэл үзүүлж, дурсгалын зүйл гардууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газар сум дундын Ойн ангитай хамтран Тамгын газрын харьяаны 11 ахмад настан, 2, 3 дугаар багийн өндөр настан 9, нийт 20 өрхөд тус бүр 1 машин түлшний модны дэмжлэг үзүүллээ.

Худалдаа үйлчилгээ, аж ахуйн нэгж байгууллагын цагийн хуваарь, хүнсний аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийсэн.

6 иргэнд 9800 боодол өвс тээвэрлэх гарал үүслийн гэрчилгээ, 1 аж ахуйн нэгж байгууллагад улаан буудай тээвэрлэх гарал үүслийн гэрчилгээг олгосон.

Шөвөг яраар өвчилсөн 220 ишиг, 33 ямааг эрүүл сүргээс тусгаарлан антибиотикийн эмчилгээ хийж байна. Нийт 178 малд гэрчилгээ олголт хийсэн.

“Бүтээлийн нуур” ХХК, “Шинэбадрах” ХХК, Улаанбаатар төмөр замын мод боловсруулах үйлдвэрийн 2020 оны үлдэгдэл модыг хийлгэж, талбай тусгаарлалтын төгсгөлийн актыг үйлдэж мод бэлтгэсэн талбайн цэвэрлэгээг хүлээн авч ажилласан. Сум дундын ойн ангитай хамтран “Бүтээлийн нуур” ХХК-ий бөөрөнхий мод болон модон материалын тооллого хийсэн.

Шинэчилсэн хаягийн мэдээллийн санд бүртгэл хийх ажил нийт 85 гудамжнаас 84 гудамж буюу хашааны хаяг 98.8 хувь, нэгж талбар 1360-аас 49 нэгж талбарыг шинэчилсэн бөгөөд 3.6 хувьтай явж байна.

Шаамар сум:

Монгол Улсын Шадар сайдын 146 тушаалаар “Зорчигч тээврийн үйлчилгээг зохион байгуулах түр журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

Сумын хэмжээнд эргүүл хяналтыг 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр, шуурхай штабыг 24 цагаар, Шаамар 6, Дулаанхаан 4-н замын хяналтын постыг тус тус ажиллуулж байна. Улаанбаатар хотоос 6 тээврийн хэрэгсэлтэй 28 хүн ирснийг халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зөвлөмжийн баталгааны маягт бөглүүлэн гэрийн ажиглалтад аваад байна. Гэрийн ажиглалтад нийт 14 өрхийн 34 том хүн 13 хүүхэд байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/04 дугаар, сумын Засаг даргын А/03 “Цэргийн тоо бүртгэл зохион байгуулах тухай” захирамжийн дагуу холбогдох ажлыг хэрэгжүүлж байна.

Мөн аймгийн Засаг даргын 2021 оны А/15 дугаар “Бүх нийтийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай” захирамжийн хүрээнд төр, төсвийн болон хувийн аж ахуйн нэгжийн нийт 32 байгууллагын 10586.2 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт их цэвэрлэгээг хийлээ.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

МЭРГЭЖИЛТЭН

Д.АЛТАНТУЯА